



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



▶ МОНГОЛ УЛС ДАХЬ ЦЭРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГАА

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН 29, 105 ДУГААР КОНВЕНЦОД НИЙЦЭЖ БАЙГАА
ЭСЭХЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



► Монгол Улс дахь цэргийн хөдөлмөрийн судалгаа:

Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын
хөдөлмөрийн байгууллагын 29, 105 дугаар
конвенцод нийцэж байгаа эсэхэд хийсэн
үнэлгээний тайлан

© Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага 2024

Анхны хэвлэл. 2024.



Attribution 4.0 International (CC BY 4.0)

Энэхүү хэвлэлийг Creative Commons Attribution 4.0 Олон улсын тусгай зөвшөөрлийн хүрээнд олон нийтэд нээлттэй байршуулсан болно (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>). Тусгай зөвшөөрлийн хүрээнд уг тайланг дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх боломжтой. Ингэхдээ ОУХБ-ыг хэвлэлийн анхны хувилбарыг эзэмшигч гэдгийг тодорхой тусгаж өгнө. Дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх тохиолдолд ОУХБ-ын логог ашиглахыг хориглоно.

Зохиогч – Хэвлэлийг дараах байдлаар эшлэнэ: *Монгол Улс дахь цэргийн хөдөлмөрийн судалгаа: Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29, 105 дугаар конвенцод нийцэж байгаа эсэхэд хийсэн үнэлгээний тайлан*. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2024. ©ОУХБ.

Орчуулга – Энэхүү хэвлэлийг орчуулсан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулсан байх ёстой: Энэ нь ОУХБ-ын зохиогчийн эрх бүхий бүтээлийн орчуулга юм. ОУХБ нь энэхүү орчуулгыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-ын албан ёсны орчуулга биш юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд орчуулан гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Өөрчлөлт – Хэвлэлийн агуулгыг өөрчлөн гаргасан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулна: Энэхүү бүтээл нь ОУХБ-аас гаргасан зохиогчийн эрх бүхий бүтээлийг өөрчлөн боловсруулсан хувилбар юм. ОУХБ нь энэхүү хувилбарыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-аас албан ёсоор өөрчлөн боловсруулсан хувилбар биш болно. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд өөрчлөн гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Гуравдагч талын материал – Энэхүү тусгай зөвшөөрөл нь бүтээлд тусгагдсан ОУХБ-ын бус зохиогчийн эрхтэй хэсэгт хамаарахгүй. Хэрэв тус хэвлэлд эшлэгдсэн гуравдагч талын зохиогчийн эрх бүхий материалыг ашиглах бол эзэмших эрх болон аливаа зөрчлийн асуудлаар зөвхөн тухайн зохиогчид хандана.

Тусгай зөвшөөрлийн дагуу үүссэн, эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссын Арбитрын журмын дагуу арбитрын шүүхэд шилжүүлнэ. Маргааныг арбитрын шүүх эцэслэн шийдэх бөгөөд талууд шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

Зохиогчийн эрх болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа асуудлаар ОУХБ-ын Хэвлэлийн албанд (Зохиогчийн эрх ба тусгай зөвшөөрөл) rights@ilo.org хаягаар хандана уу. ОУХБ-ын хэвлэл болон дигитал бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: www.ilo.org/publns.

ISBN: 978-92-2-040599-4 (Хэвлэмэл), 978-92-2-040600-7 (веб PDF)

Энэхүү хэвлэлийн англи хэл дээрх хувилбар: *Assessing compliance of conscripts and career members of the Mongolian armed forces with ILO Conventions Nos. 29 and 105 on forced labour*. Geneva and Ulaanbaatar: International Labour Office, 2024. © ILO. ISBN: 978-92-2-040598-7 (print); 978-92-2-040542-0 (web PDF)

ОУХБ-ын мэдээллийн сан, хэвлэлд ашиглагдсан материал нь НҮБ-ын зарчимд нийцсэн бөгөөд ОУХБ-ын аливаа улс орон, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, эрх мэдэл, эсвэл тэдгээрийн хил хязгаарын талаарх илэрхийлсэн байр суурь, илэрхийлэл биш болно.

Хэвлэлд тусгагдсан үзэл, санаа бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд ОУХБ-ын үзэл, санаа бодол, эсвэл бодлого биш юм.

Байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг эш татах нь ОУХБ-аас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэсэн утгыг илэрхийлэхгүй. Мөн бусад байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь хүлээн зөвшөөрөөгүйн шинж биш юм.

Энэхүү судалгааг АНУ-ын Хөдөлмөрийн яамны санхүүжилтээр хэрэгжүүлж буй IL-30147-16-75-K-11 (MAP16) төслийн хүрээнд гүйцэтгэж, тайланг хэвлэв.

Монгол Улсад хэвлэв.

► Өмнөх үг

Монгол улс олон намын тогтолцоо бүхий ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засагт шилжин хөгжлийн шинэ үеийг эхлүүлсэн билээ. Монгол улсын эдийн засаг төдийлөн төрөлжиж чадаагүй ч гэсэн хурдацтай өсч байна. Монгол улс дэлхийн зах зээл дээр Европын холбоо, АНУ зэрэг орнуудтай хөрөнгө оруулалт, худалдаагаа өргөжүүлж, олон улсын худалдаанд улам гүн нэгдэж орсныг харуулж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас үлдсэн зарим практик, үйл ажиллагаа нь хүний эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа нь олон улс, үндэсний түвшний хүний эрхийн байгууллагуудын анхаарал татсан асуудлуудын нэг болоод байна. Үүний нэг тод жишээ бол хугацаат цэргийн алба хаагчдыг цэргийн бус ажил, үйлчилгээ гүйцэтгүүлж, эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулдаг практик юм.

Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр конвенц нь хугацаат цэргийн алба хаагчийг зөвхөн цэргийн зориулалттай ажил, үйлчилгээ гүйцэтгэхийг зөвшөөрдөг бөгөөд Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенц нь төрөөс албадан хөдөлмөрлүүлэх нөхцлүүд, түүнчлэн хувийн хэвшилд албадан хөдөлмөрийг ашиглахыг хориглох тухай заасан байдаг. Үүнд хугацаат цэргийн алба хаагчийг эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулах хамаарна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хорооноос (цаашид Шинжээчдийн хороо гэх) Монгол улсын Засгийн газарт энхийн цагт эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцож байгаа буюу цэргийн бус шинж чанартай ажилд дайчлагдан ажиллаж байгаа цэргийн тоо, бусад мэдээлэл, түүнчлэн зэвсэгт хүчний ахлагч, офицерийн хөдөлмөрийн нөхцөл, тэр дундаа албанаас сайн дураар чөлөөлөгдөх нөхцөлтэй холбоотой мэдээллийг гаргаж өгөх хүсэлтийг хүргүүлсэн билээ.

Энэ хүсэлтийн хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-аас Монгол улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-той хамтран тоон судалгааг гүйцэтгэсэн бөгөөд судалгаанаас хугацаат цэргийн алба хаагч албадан хөдөлмөр эрхэлж байгаа тухай дүгнэлт хийж болохоор үр дүн харагдаж байна.

Энэхүү судалгаанд ҮСХ-ны судалгаатай уялдуулан хугацаат цэргийн алба хаагчийн хөдөлмөр, зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын энхийн цагт албанаас чөлөөлөгдөхтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, бодлогын орчинд дүн шижилгээ хийлээ.

Судалгааг 2023 оны 9, 10 дугаар саруудад Барилга-инженерийн цэргийн 339, 017, Зэвсэгт хүчний 120, 256 дугаар ангиудад гүйцэтгэж, хугацаат цэргийн

192 алба хаагч, цэргийн алба хаасан 100 гаруй иргэнийг хамруулж, бүлгийн ярилцлага хийсэн болно.

Уг судалгаагаар Монгол улсын Зэвсэгт хүчний тухай хууль нь хугацаат цэргийн алба хаагчдыг цэргийн бус ажилд оролцуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн нь ОУХБ-ын 29, 105 дугаар конвенц болон Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуультай нийцэхгүй байна. Судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь дор хаяж нэг удаа онцгой байдалд үл хамаарах бөгөөд цэргийн бус зориулалттай ажил, үйлчилгээ эрхэлсэн нь хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн бус ажил нь албадан хөдөлмөрийн шинж агуулж байгааг харуулж байна.

Зэвсэгт хүчний офицер, ахлагчдын хувьд ахиц гарчээ. Офицер, ахлагч нар Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу албанаас сайн дурын үндсэн дээр чөлөөлөгдөж болох бөгөөд энэ эрхээ ямар нэг саадгүйгээр хэрэгжүүлэх боломжтой болохыг судалгаа харуулж байна.

Судалгааны тайланд хугацаат цэргийн албаны тухай Монгол улсын хууль тогтоомж, бодлого, түүнийг хэрэгжилтийг Монгол улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцод бүрэн нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байгааг тэмдэглэсэн болно.

Энэхүү тайлан нь хугацаат цэргийн хөдөлмөрийн асуудлыг Монгол улсад төдийгүй, олон улсын түвшинд үргэлжлүүлэн хэлэлцэж, санал солилцох сэдэл болно гэдэгт итгэж байна.

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв болон судалгаанд дэмжлэг үзүүлсэн цэргийн анги хамт олонд талархал илэрхийлье.



Чанхи Ли

ОУХБ-ын БНХАУ, Монгол улсыг
хариуцсан товчооны захирал



Филип Ванхейнегем

ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний
суурь зарчим ба эрхийн асуудал
хариуцсан хэлтсийн дарга

► Талархал

Энэхүү тайланг ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтсийн Судалгаа, үнэлгээний нэгжийн Бодлогын судлаач Мария Габриелла Бреглиагийн чиглэл зөвлөмжийн дагуу Үндэсний судалгаа, зөвлөгөөний төвийн захирал Батчулууны Алтанцэцэг, судлаач Батчулууны Хишигсайхан, Батбэхийн Соёлмаа нар гүйцэтгэлээ. Судалгааны ажлын бүхий л үе шатанд ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтсийн Судалгаа, үнэлгээний нэгжийн дарга Микиел Де Коок, Үндэсний зохицуулагч Пүрэвсүрэнгийн Болормаа нар техникийн туслалцаа үзүүлж ажиллалаа. Түүнчлэн Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс болон гишүүн Батзэвэгийн Энхболдод энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, зөвлөгөө өгч ажилласанд гүн талархал илэрхийлж байна.

► АГУУЛГА

Өмнөх үг	iii
Талархал	v
Товчилсон үгийн жагсаалт	x
1. Оршил	1
2. Арга зүй	3
2.1. Судалгааны дизайн	3
2.1.1. Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаа	4
2.1.2. Хугацаат цэргийн алба хаасан иргэдийн судалгаа	5
2.1.3. Экспертийн ярилцлага	5
3. Суурь судалгаа	7
3.1. Зэвсэгт хүчний онцлог	7
3.1.1. Монгол Улсын хугацаат цэргийн алба хаагчдын тоо	7
3.1.2. Зэвсэгт хүчний тогтолцоо: Барилга-инженерийн ангиуд	7
3.1.3. Зэвсэгт хүчинд гомдол шийдвэрлэх механизм	8
3.1.4. Энхийн цагт зэвсэгт хүчний албанаас чөлөөлөгдөх нөхцөл	9
3.1.5. Хугацаат цэргийн алба хаагчийн заавал хамрагдах болон сайн дурын сургалт	9
3.1.6. Хугацаат цэргийн алба хаагчийн онцгой байдлын үед гүйцэтгэх үүргийг зохицуулсан эрх зүйн орчин	10
3.2. Цэргийн хөдөлмөр: Бодлого, эрх зүйн орчин	11
3.3. Хугацаат цэргийн алба хаагчийн цэргийн бус хөдөлмөр	17
3.4. Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцын талаарх мэдлэг	18

4. Үр дүн 19

4.1.	Тоон судалгаа	19
4.1.1.	Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаа	19
4.1.2.	Халагдсан цэргийн судалгаа	20
4.2.	Хугацаат цэргийн алба хаагчдын эрхэлдэг ажлын төрлүүд	20
4.3.	Хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн бус хөдөлмөр	25
4.4.	Цэргийн бус ажлын төрлүүд	26
4.5.	Хугацаат цэргийн алба хаагчдын хөдөлмөрийн нөхцөл	28
4.5.1	Цэргийн бус ажлын цалин хөлс	28
4.5.2	Ажлын өдөр, цаг	30
4.5.3	Хөдөлмөрийн аюулгүй байдал	31
4.6.	Сургалт	32
4.7.	Онцгой байдал	34
4.8.	Офицер, ахлагчдын хөдөлмөрийн нөхцөл	35
4.8.1.	Цэргийн албанаас чөлөөлөгдөх	35
4.8.2.	Хөдөлмөрийн нөхцөл	36
4.8.3.	Гомдол гаргах журам	37

5. Дүгнэлт 39

6. Зөвлөмж 41

Ашигласан материалын жагсаалт	42
Хавсралт: Асуумжийн хуудас болон ярилцлагын асуултууд	43

► Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны үйл явцын тойм	3
Хүснэгт 2. Барилга-инженерийн цэргийн ангиуд ¹	8
Хүснэгт 3. Онцгой байдлын үед цэргийн алба хаагчийн гүйцэтгэх үүрэг	10
Хүснэгт 4. Зэвсэгт хүчний тухай хууль, 2002 болон 2016 он: Улсыг хөгжүүлэх болон бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчнийг оролцуулах талаарх холбогдох заалт	12
Хүснэгт 5. Бодлогын бусад баримт, бичиг	13
Хүснэгт 6. Хугацаат цэргийн алба хаагч болон офицер, ахлагчийн хөдөлмөрт хамааралтай хууль	13
Хүснэгт 7. Хугацаат цэргийн алба хаагч болон офицер, ахлагчийн хөдөлмөрт хамааралтай журам	14
Хүснэгт 8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 208 дугаар зарлиг: “Бүтээн байгуулалт”, “аж ахуйн ажил”-ын тодорхойлолт	15
Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан цэргийн алба хаагчдын шинж чанар	19
Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан халагдсан цэргийн шинж чанар	20
Хүснэгт 11. Цэргийн шинжтэй болон цэргийн бус ажил хийсэн байдал, хувиар	25
Хүснэгт 12. Цэргийн бус ажлын байршил	27
Хүснэгт 13. Мэргэшил олгох сургалт, цэргийн ангиар	32

► Зургийн жагсаалт

Зураг 1.	Зэвсэгт хүчнийг аж ахуйн ажилд оролцуулах	16
Зураг 2.	Хугацаат цэргийн алба хаагчийн эрхэлсэн ажлын төрлүүдийн тоо	22
Зураг 3.	Хугацаат цэргийн алба хаагч эрхэлсэн ажлын төрлүүдийн тоо: барилга инженерийн ба бусад цэргийн анги	23
Зураг 4.	Цэргийн болон цэргийн бус хөдөлмөр, сургалт, цэргийн анги, нэгтгэлээр	24
Зураг 5.	Хугацаат цэргийн алба хаагчдын хийдэг цэргийн бус ажлын төрлүүд	26
Зураг 6.	Цэргийн бус ажлын сонголт (хувиар)	27
Зураг 7.	Цэргийн бус хөдөлмөрийн цалин хөлс	29
Зураг 8.	Цэргийн бус хөдөлмөрт зарцуулсан ажлын цаг	30
Зураг 9.	Барилга инженерийн ангид хугацаат цэргийн алба хаагчдын мэргэшил олгох сургалтаар хийсэн цэргийн бус хөдөлмөр	33
Зураг 10.	Бусад алба хаагчдын мэргэшил олгох сургалтаар хийсэн цэргийн бус хөдөлмөр	34

► **Товчилсон үгийн жагсаалт**

КЗХХШХ	Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хороо
МУЗХ	Монгол Улсын Зэвсэгт хүчин
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАБЭМ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
Эн Ар Си Си	Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв

► 1. Оршил

Монгол Улс өнгөрсөн гуч гаруй жилд олон намын тогтолцоо бүхий ардчилсан нийгэмд амжилттай шилжин, эдийн засаг нь төрөлжөөгүй ч хурдацтай өсжээ. Монголын эдийн засаг дэлхийн зах зээлд, ялангуяа Европын холбоо, АНУ зэрэг худалдааны гол түншүүдтэй худалдаа, хөрөнгө оруулалтыг чөлөөлөх нөхцөл тогтоосноор улам бүр интеграцлагдаж байна. Гэхдээ олон улсын болон үндэсний хүний эрхийн байгууллага, Монгол Улсын худалдааны түншүүдийн сэтгэл зовоосон тодорхой зарим хэвшил төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеэс үлдэж хоцорсон байна. Тийм хэвшил дадлын нэг нь хугацаат цэргийн алба хаагчдыг цэргийн бус хөдөлмөр, эдийн засгийн бүтээн байгуулалтад ашиглаж буй практик юм.

ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр конвенцод албадан хөдөлмөрийг тодорхойлохдоо:

“Ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, чингэхдээ уг этгээд нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил буюу үйлчилгээг хэлнэ”.

Гэхдээ заавал хаах цэргийн албаны хүрээнд гүйцэтгүүлэх цэвэр цэргийн ажил, үйлчилгээг албадан буюу заавал хийх хөдөлмөрийн дээрх тодорхойлолтод хамааруулдаггүй. “Цэвэр цэргийн” гэдэг нөхцөл нь нийгэмд тустай хөдөлмөрт цэрэг дайчлахаас урьдчилан сэргийлэхэд чиглэж байна. Энэ хориг нь албадан буюу заавал хийх хөдөлмөрийг “эдийн засгийн хөгжлийн зориулалтаар хөдөлмөрийг дайчлах, хэрэглэх арга” хэмээн хориглодог 105 дугаар конвенцын 1 дүгээр зүйлийн (b) хэсгийн заалтаас үүдэн гарсан.

Цэвэр цэргийн ажил гэдгийг улс орноо хамгаалахад чиглэсэн үүрэг даалгавар гүйцэтгэхийг хэлнэ. Гэхдээ 29 дүгээр конвенцод заасан албадан хөдөлмөрт хамаарахгүй зарим онцлог нөхцөлүүд байгаа болно. Үүнд:

- Хугацаат цэргийн алба хаагч бусад иргэний адилаар онцгой байдал үүссэн тохиолдолд ажиллах;
- Инженерийн буюу түүнтэй төстэй цэргийн ангид алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчдыг зам, гүүр барих ажилд цэргийн бэлтгэл, сургуулилалтын хүрээнд оролцуулах;
- Хугацаат цэргийн алба хаагчдыг иргэний аж байдалд эргэн ороход нь тус дөхөм болох ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтад хамруулах (ILO 1979, 2007).

Монгол Улс Албадан хөдөлмөрийн тухай 29 болон 105 дугаар конвенцуудыг 2005 онд соёрхон баталсан билээ. 2019 онд Конвенц, зөвлөмжийн

хэрэгжилтийг хянах шинжээчдийн хороо (КЗХХШХ)-оос “Заавал хаах цэргийн албатай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлогдож буй аливаа ажил, үйлчилгээ нь цэвэр цэргийн шинжтэй байж, конвенцод нийцтэй болгох үүднээс хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах асуудлаар Засгийн Газарт” шаардлага хүргүүлсэн болно. Шаардлагын дагуу арга хэмжээ авах хүртэл Хорооноос цэргийн бус ажилд томилогдсон хугацаат цэргийн алба хаагчдын тоог гаргаж өгөх хүсэлтийг Засгийн Газарт хүргүүлсэн (ILO 2021). Улмаар 2022 онд КЗХХШХ-ноос “цэргийн алба хаагч энхийн цагт өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөх нөхцөл болон чөлөөлөгдөх хүсэлтийн тоо, хүсэлт хүлээн авсан болон татгалзсан талаарх тоон мэдээллийг” гаргаж өгөхийг Засгийн Газраас хүссэн болно (ILO 2023).

Дээрх шууд шаардлагуудын хариуд ОУХБ хугацаат цэргийн болон цэргийн алба хаагчдын хөдөлмөрийн нөхцөл нь 29 болон 105 дугаар конвенцтой нийцэж буй эсэхийг үнэлэх судалгааны ажил гүйцэтгэхийг дэмжсэн болно. 2022 онд ҮСХ нь ОУХБ-ын дэмжлэгтэйгээр албадан хөдөлмөрийг тодорхойлох, хугацаат цэргийн алба хаасан эрэгтэйчүүдээс албадан хөдөлмөрийн тухай судалгаа авах асуумжийн модулыг Ажиллах хүчний судалгаанд оруулан туршилт судалгаа хийсэн.¹ Уг судалгааны үр дүнд заасан хугацаанд (сүүлийн гурван жилд) цэргийн алба хаасан иргэдийн 7.27 (880 цэрэг) хувь нь алба хаах хугацаандаа цэргийн бус ажил, үйлчилгээ эрхэлсэн бөгөөд эдгээр иргэдийн нэг нь ч уг ажил нь ямар нэг онцгой байдалтай холбоотой гэж үзээгүй байна. Цэргийн бус ажил, үйлчилгээ эрхэлсэн гэх оролцогчдын 29.77 хувь (буюу 262 оролцогч) нь заавал хамрагдах сургалтын үеэр уг ажлыг хийсэн гэсэн нь албадан хөдөлмөр гэж үзэхээр байна. Бусад оролцогчдын хийсэн гэх цэргийн бус ажил нь цэргийн ангийн үүрэг чиглэлтэй холбоотой эсвэл сайн дурын сургалттай холбоотой эсэх тодорхойгүй байсан учир албадан хөдөлмөр гэж тодорхойлох боломжгүй байсан болно.

Дээрх түүвэр судалгааны учир дутагдалтай байдлын улмаас Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв болон ОУХБ хамтран 29 болон 105 дугаар конвенцын нийцтэй байдлыг үнэлэх зорилгоор чанарын болон тоон судалгаа хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны үр дүнг уг тайлангаар танилцуулж байна.

1 Цэргийн албаны тухай хуулийн 12.2-т зааснаар Монгол Улсын иргэн 18-25 насны эрэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татна гэж заасан.

► 2. Арга зүй

2.1. Судалгааны дизайн

Судалгааны баг талбарын судалгааг 2023 оны 9-р сарын 8-аас 10-р сарын 13-ны хооронд зохион байгуулсан ба эхний хоёр анги 9-р сарын 8-аас 9-ний хооронд, сүүлийн хоёр ангид 10-р сарын 12-оос 13-ны хооронд судалгаанд хамрагдсан. Хугацаат цэргийн алба хаагчид ургац хураалтад явсан байсан тул талбарын судалгаа 10 сар хүртэл хойшилсон. Офицер, ахлагч нар болон халагдсан цэргүүдийн гүнзгийрүүлсэн ярилцлагыг 10-р сарын хоёрдугаар хагаст хийсэн.

Хүснэгт 1-д үзүүлсэнчлэн, тоон өгөгдлийг экспертийн ярилцлага, гүнзгийрүүлсэн ярилцлага, болон тоон судалгааны аргаар цуглуулсан. Судалгааны эхэнд судалгаатэй холбоотой мэдээ, олон нийтэд нээлттэй эрх зүйн баримт бичиг, болон албан эх сурвалжийн мэдээллийг хайж, цуглуулан судалсны үндсэн дээр дизайн болон асуулгуудыг боловсруулсан. Хоёр тоон судалгааг асуулгаар авсан: (i) хугацаат цэргийн алба хаагч; (ii) хугацаат цэргийн албанаас халагдсан цэрэг.

► Хүснэгт 1. Судалгааны үйл явцын тойм

Экспертийн ярилцлага		№
Төрийн байгууллага		6
Зэвсэгт хүчний офицер, ахлагч		20
Цэргийн алба хаагчийн судалгаа, гүнзгийрүүлсэн ярилцлага		
Анги/	Тоон судалгаа (Оролцогчийн тоо)	Гүнзгийрүүлсэн ярилцлага (Тоо)
339-р анги, барилга инженер	56	7
017-р анги, барилга инженер	51	7
120-р анги, зэвсэгт хүчин	35	
256-р анги, зэвсэгт хүчин	50	7
Хугацаат цэргийн албанаас халагдсан цэргийн судалгаа, гүнзгийрүүлсэн ярилцлага		
Анги/	Тоон судалгаа (Оролцогчийн тоо)	Гүнзгийрүүлсэн ярилцлага (Тоо)
Халагдсан цэрэг	100	10

2.1.1. Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаа

Тоон өгөгдөл, мэдээллийг асуулга болон сонгогдсон цэргийн алба хаагчтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийх аргаар цуглуулсан.

Судалгаанд 192 хугацаат цэргийн алба хаагч хамрагдсан. Оролцогчдын тоог судалгаагаар олон төрлийн оролцогчдын талаарх тоон өгөгдөл, мэдээлэл цуглуулах боломжтой байхаар сонгосон. Судалгаа нь хугацаат цэргийн алба хаагчдыг статистикийн хувьд төлөөлөх түүвэр сонгох зорилго тавиагүй. Тоон өгөгдлийг зэвсэгт хүчний дөрвөн цэргийн ангийн (Улаанбаатарын барилга инженерийн анги, Баянхонгор *аймгийн* барилга инженерийн анги, Өвөрхангай болон Төв *аймгийн* цэргийн анги) хугацаат цэргийн алба хаагчдаас цуглуулсан.² Баянхонгор аймагын барилга инженерийн анги нь өмнө хийгдсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын (ОУХБ ХЭҮК, 2016) судалгаанд хамрагдсан хоёр ангийн нэг байсан тул сонгосон. Харин Улаанбаатар хотын барилга инженерийн ангийг хот, хөдөөгийн нөхцөлийг харьцуулах зорилгоор сонгосон. Түүнчлэн үлдсэн хоёр ангийг барилга инженерийн ангийн нөхцөл байдлыг зэвсэгт хүчний бусад ангитай харьцуулахын тулд сонгосон. 17 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын тоо хүрэлцэхгүй байсан тул 120 дугаар анги нэмэгдсэн.

Судалгаанд ОУХБ-ын мэргэжилтнүүд болон өмнө хийгдсэн ОУХБ болон ХЭҮК-ын судалгааны судлаачидтай хийсэн хэлэлцүүлэгт үндэслэн боловсруулсан асуулгыг ашигласан. Уг асуулга нь хугацаат цэргийн алба хаагчид, тэдний хөдөлмөр болон сургалтын шинж чанарын талаарх тоон өгөгдөл цуглуулах зорилготой бөгөөд хугацаат цэргийн алба хаагчийн хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл, сургалтын агуулгын талаарх ойлголт, гомдол гаргах механизмын талаарх тэдний туршлагын талаар мэдээлэл авах асуултуудыг багтаасан. Асуулгын асуултууд хоорондын нийцэл болон ойлгомжтой байдлыг туршилтын судалгаагаар шалгасан.

Онлайн асуулгын маягтыг боловсруулсан бөгөөд судалгааны мэдээллийг онлайнгаар мэдээлэл цуглуулдаг программ ашиглан цуглуулсан. Судалгааны үеэр судалгаанд оролцогчдод мэдээлэл цуглуулах төхөөрөмж (утас) тараан, интернэтийг модемоор цацсан.

Анги тус бүрээс 4-5 хугацаат цэргийн алба хаагчийг сонгон авч гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Онлайн мэдээлэл цуглуулах программ ашигласан тул ярилцлагад оролцогчдыг асуулга өгсөн даруйд нь тэдний хариулт дээр үндэслэн сонгох боломжтой болсон. Оролцогчдыг үндэс угсаа, цэргийн бус ажил хийсэн эсэх талаарх тодорхой асуултад өгсөн хариултыг үндэслэн сонгосон. Цэргийн ангид гүнзгийрүүлсэн ярилцлагыг ганцаарчилсан ярилцлага хийх боломжтой тусдаа өрөөнд хийж, цэргийн алба хаагчийн ажил хөдөлмөр, сургалтын талаар илүү мэдээлэл цуглуулах зорилгоор тусгайлан бэлдсэн удирдамжийн дагуу авсан.

2 Монгол Улс засаг захиргааны 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хуваагддаг .

2.1.2. Хугацаат цэргийн алба хаасан иргэдийн судалгаа

2016-2022 оны хооронд цэргийн алба хаагаад халагдсан 100 иргэнийг цасан бөмбөгийн түүврийн аргаар сонгон, судалгаанд хамруулсан. Эхний хэдэн оролцогчдыг эхлээд хэд хэдэн байршил болон алба хаасан хэд хэдэн оноос сонгосон. Цэргийн алба хаасан иргэдийн мэдээлэл нууц учраас тэдний тухай мэдээлэл бүхий жагсаалтыг олж авах боломжгүй юм.

Хугацаат цэргийн алба хаагаад халагдсан цэргийн судалгаанд хугацаат цэргийн алба хаагчдын судалгааны тоон өгөгдөлтэй харьцуулах боломжтой байхуйцаар боловсруулсан асуулга ашигласан. Асуулга нь судалгаанд хамрагдагсад, цэргийн алба хааж байх хугацаандаа хийсэн ажил, сургалтын шинж чанарын талаарх тоон мэдээлэл цуглуулах зорилготой бөгөөд тэдний ажил, хөдөлмөрийн нөхцөл, сургалтын агуулга, өргөдөл гомдлын процессын практик хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах асуултуудыг багтаасан болно. Асуулгын асуултууд хоорондын нийцэл, ойлгомжтой байдлыг туршилтын судалгаагаар шалгасан. Судалгаанд онлайн мэдээлэл цуглуулах программыг ашигласан бөгөөд онлайн асуулгын маягт бэлтгэсэн.

Цэргийн алба хааж байх үеийн сургалт, хөдөлмөрийн талаар нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор арван оролцогчийг гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцуулахаар сонгож тусгайлан бэлдсэн удирдамжийн дагуу ганцаарчилсан ярилцлага хийсэн.

2.1.3. Экспертийн ярилцлага

Хугацаат цэргийн албаны эрх бүхий төрийн байгууллага болон хугацаат цэргийн алба хаагчдын сургалт, ажилтай холбоотой бусад байгууллагуудын зургаан төлөөлөлтэй уулзаж ярилцсан. Ярилцлагын удирдамжийг судалгааны эхний бэлтгэл шатанд цуглуулсан мэдээлэлд үндэслэн боловсруулсан болно. Мөн хорь орчим ээвсэгт хүчний офицер, ахлагчидтай ярилцлага хийсэн.

Судалгааны ёс зүй. Албадан хөдөлмөрийн талаарх судалгаа нь ярилцлага өгч байгаа болон авч байгаа талуудын аль алиныг хамгаалах үүднээс ёс зүйн асуудлыг нухацтай авч үзэх шаардлагатай болдог. Судалгааг явуулахдаа дараах ёс зүйн зарчмуудыг баримталсан.

Судалгаа авахын өмнө судалгааны талаар мэдээлэл өгч, судалгаанд оролцогчдын зөвшөөрлийг авсан. Оролцогчдын нууцлалыг хангах үүднээс асуулгад овог нэр, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах мэдээлэл зэрэг ямар ч хувийн мэдээлэл цуглуулаагүй. Судалгаанд оролцогчдоос гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдыг санамсаргүй сонгохдоо судалгааны багийн үүсгэсэн кодыг ашигласан.

Үүний нэгэн адил ээвсэгт хүчний офицер, ахлагчид, халагдсан цэргүүд болон хугацаат цэргийн алба хаагчидтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийхдээ эхлээд тэдний зөвшөөрлийг авсан.

► 3. Суурь судалгаа

3.1. Зэвсэгт хүчний онцлог

3.1.1. Монгол Улсын хугацаат цэргийн алба хаагчдын тоо

Хугацаат цэргийн алба хаагчийн талаарх нарийн мэдээлэл нь Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн нууцын жагсаалт (м-6, н-6, у-2, я-5,6-р хэсэг)-ын дагуу төрийн нууцад хамаардаг. Иймд бид судалгаанд ҮСХ-ны олон нийтэд нээлттэй мэдээлэл болон УИХ-ын хуралдааны үеэр иргэдэд өгсөн мэдээллийн тоон өгөгдлийг ашигласан.

УИХ-ын гишүүн Ж. Энхбаярын өгсөн мэдээллээр, жил бүр цэргийн насны 80-90 мянга орчим залуус цэргийн жинхэнэ албанд тэнцэж, 3 хувь нь цэргийн алба хаадаг байна.³ Эндээс үзэхэд ойролцоогоор 2400-2700 орчим хүн цэрэгт татагддаг бол ҮСХ-ны мэдээгээр 2022 онд цэргийн насны 186,100 эрэгтэй байна. Хэрэв 3 орчим хувь нь цэргийн алба хааж байгаа бол 2022 онд ойролцоогоор 5,600 хүн цэрэгт татагдсан гэж үзэхээр байна.

3.1.2. Зэвсэгт хүчний тогтолцоо: Барилга-инженерийн ангиуд

2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн нууцын жагсаалтад (е-7,32,37,38,39,41, ё-11,12, ф-4) заасны дагуу цэргийн тогтолцооны бүтэц, нэгжийн тоо, нэгжийн мэргэшлийн жагсаалт, анги тус бүр дэх хугацаат цэргийн алба хаагчдын тоотой холбоотой мэдээллийг төрийн нууцад хамааруулдаг. Тиймээс бид энэ судалгаанд барилга инженерийн нэгжүүдийн талаарх дараах мэдээллийг олон нийтэд нээлттэй албан ёсны эх сурвалжаас авсан болно.

Барилга инженерийн цэргийн удирдах газар нь барилга инженерийн ангиудыг хариуцдаг. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяртай хийсэн ярилцлагаас харахад Монгол Улсад барилга инженерийн есөн анги байдаг бол⁴ Барилга

3 УИХ-ын 2020 оны тавдугаар сарын 8-ны өдрийн хуралдааны мэдээ. <https://news.mn/r/2297653/>.

4 Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяртай ярилцлаа (2023.01.23). <http://time.mn/sAs.html>. https://www.facebook.com/permalink.php?story_fbid=5790455617737179&id=765656853550439&paipv=0&eav=Afa6F-kBmCL6QELcTtudxvZUGuCuCuI1q19Aa2glPSV4&_rdr.

инженерийн цэргийн удирдах газрын цахим хурлын мэдээгээр долоон анги байна.⁵ Энэхүү тайланд дурдсан барилга инженерийн долоон нэгжийн талаарх мэдээллийг янз бүрийн албан ёсны нээлттэй эх сурвалжаас олж авсан (хүснэгт 2).

► Хүснэгт 2. Барилга-инженерийн цэргийн ангиуд¹

	Анги	Үүрэг	Байршил	Он
1	342	Барилгын инженерчлэл	Архангай *	2021 он
2	338	Барилгын инженерчлэл	Сүхбаатар **	2010 он
3	339	Барилгын инженерчлэл	Баярхонгор **	2010 он
4	340	Барилгын инженерчлэл	Баян-Өлгий **	2010 он
5	017	Барилгын инженерчлэл	Улаанбаатар ***	
6	341	Барилгын инженерчлэл	Говь-Алтай ****	2021 он
7	110	Барилгын инженерчлэл	Орхон	2016 ²

Тайлбар: ¹ Өмнөговь аймгийн барилга инженерийн ангийн (223) тухай дурдсан хоёр эх сурвалж байдаг боловч энэ нэгж албан ёсны вэбсайтад байдаггүй: <https://gogo.mn/r/w88q0>; <http://www.ekhoron21.mn/aimag.php/a/11/r/5076>. Байгуулагдсан оныг ярилцлагад байгаа мэдээллээс тооцоолсон.²

Эх сурвалж: * <https://montsame.mn/mn/read/282957>. ** <https://montsame.mn/mn/read/17706>. <https://gogo.mn/r/65211>. *** <https://montsame.mn/mn/read/17706>. **** <https://vip76.mn/content/79889>.

Тухайн нэг ангийн хугацаат цэргийн алба хаагчдын тоо 100-аас 500-гийн хооронд хэлбэлздэг бөгөөд⁶ Батлан хамгаалахын сайд Ч.Сайханбаярын мэдээлснээр БНХАУ-ын Мандал боомтыг холбосон төмөр зам барих ажилд барилга инженерийн зургаан ангийн 1000 гаруй цэргийн алба хаагч оролцсон байна.

3.1.3. Зэвсэгт хүчинд гомдол шийдвэрлэх механизм

Өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх нийтлэг эрх нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдана. Цэргийн алба хаагчийн өргөдөл, гомдол гаргах эрх

5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн цахим хурлын мэдээ. (2023 оны 6-р сарын 6) <https://gsmaf.gov.mn/thtsk/one-Post/74>.

6 <https://gogo.mn/r/w88q0>; <http://www.ekhoron21.mn/aimag.php/a/11/r/5076>.

зүйн үндсийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “байлдааны бэлэн байдал, хууль бус үйлдэл, хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар санал хүсэлт, гомдлоо бүх шатны захирагч, дарга нарт амаар болон бичгээр тавьж, шийдвэрлүүлэх” хэмээн тусгаж өгсөн.

Энэ хүрээнд нарийвчлан зохицуулсан журмыг Ерөнхийлөгчийн 2019 оны 17-р зарлигаар баталсан Цэргийн нийтлэг дүрмийн Хавсралт 16-аар баталжээ. Тус журмын 7-д “Цэргийн алба хаагч аливаа асуудлаар өргөдөл, хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэхдээ зөвхөн ангийн захирагчаар уламжлуулан харьяа салбарын сайд, мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын дарга, төрлийн цэргийн командлагчид хандана” гэж заасан. Тус журмын 17-д журмын 7-р заалтыг зөрчсөн нь цэргийн алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно хэмээх заалт зөрчил дагуулахаар байна. Учир нь ангийн захирагчийн талаар гомдол гаргах тохиолдолд өөрөөр нь дамжуулж гомдол гаргах эсэх нь эргэлзээтэй.

3.1.4. Энхийн цагт зэвсэгт хүчний албанаас чөлөөлөгдөх нөхцөл

Цэргийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6-д цэргийн алба хаагчийн өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөхөөр зохицуулсан байна. Цэргийн алба хаагчийн цэргээс халагдсан, чөлөөлөгдсөн мэдээлэл төрийн нууцад хамаарах тул өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн цэргийн алба хаагчийн мэдээллийг гаргах боломжгүй болно.

3.1.5. Хугацаат цэргийн алба хаагчийн заавал хамрагдах болон сайн дурын сургалт

Зэвсэгт хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.7-д “цэргийн алба хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах” үүргийг хүлээлгэсэн бөгөөд өөр заавал хамрагдах сургалт хуульд тусаагүй. Харин цэргийн алба хаагчийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах үүднээс мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн сайд, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар зохицуулсан байна.⁷ Тус журмын 2.4-т сургалтад хамрагдах цэргийн алба хаагч өргөдөл гаргахаар зохицуулсан нь тус сургалтад хамрагдахаа цэргийн алба хаагч хүсэлт гаргаж буюу сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэхээр зохицуулсан гэж дүгнэхээр байна.⁸ Мөн тус журамд зааснаар суралцагчдад мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ

⁷ Зэвсэгт хүчний тухай хууль, 13 дугаар зүйлийн 13.1.13

⁸ Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/70/А/58 хамтарсан тушаал, 2-р зүйлийн 2.4

олгоно.⁹ Гэвч мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал ХНХЯ-аас БШУЯ-д шилжсэнтэй холбогдуулан тус журмын үйлчлэл тодорхойгүй болоод байгаа нь цэргийн ангиудад ажиллах үеэр мэдэгдсэн.

3.1.6. Хугацаат цэргийн алба хаагчийн онцгой байдлын үед гүйцэтгэх үүргийг зохицуулсан эрх зүйн орчин

Онцгой байдлын үед авах арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай, Онц байдлын тухай хуулиар тус тус зохицуулагдаж байна. Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд онц байдал зарлах үндэслэлийг нарийвчлан зааж өгсөн. Онц байдал зарлах бүрэн эрх УИХ-д байх бөгөөд хойшлуулшгүй тохиолдолд МУ-ын Ерөнхийлөгч онц байдал зарлах тухай зарлиг гаргаж, УИХ уул зарлиг гарснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно.¹⁰

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4-р зүйлд гамшиг, гамшгийн эрсдлийг хэрхэн авч үзэхийг тодорхойлсон. Тус хуулиар гамшгаас хамгаалах бэлэн байдлыг өдөр тутмын, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт ангилан үзсэн бөгөөд өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэргийг тогтоох албан тушаалтныг тус хуулийн 11.3-т нарийвчлан зааж өгсөн. Харин өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тодорхой үндэслэлийг хуульд нарийвчлан заагаагүй бөгөөд энэ нь тус хуулийн 7 дугаар зүйлээр зохицуулсан гамшгийн эрсдлийн үнэлгээнд тулгуурлахаар байна.

► Хүснэгт 3. Онцгой байдлын үед цэргийн алба хаагчийн гүйцэтгэх үүрэг

№	Хуулийн нэр, холбогдох зүйл, заалт	Гүйцэтгэх чиг үүрэг
1	Онц байдлын тухай хууль, 12-р зүйл	► Нийгмийн дэг журам сахиулахтай холбоотой чиг үүргүүд ► Онц байдлын үр дагаврыг арилгах, аврах, хамгаалах, сэргээн босгох ажилд оролцуулах
2	Гамшгаас хамгаалах тухай хууль, 26, 28.1.8, 30.1.17,	► Тус хуулиар гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн байгууллагыг татан оролцуулах асуудлыг зохицуулсан боловч хийх чиг үүргийг тухайлан заагаагүй байна.

9 Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам, 3-р зүйлийн 3.6.3, 4-р зүйлийн 4.2

10 Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 33 дугаар зүйлийн 33.1.12, Онц байдлын тухай хуулийн 5-р зүйл

3.2. Цэргийн хөдөлмөр: Бодлого, эрх зүйн орчин

Цэргийн алба хаагчийн хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус зохицуулж байна. Харин хугацаат цэргийн хөдөлмөрийг Зэвсэгт хүчний тухай хуулиар зохицуулсан. Цэргийн албаны тухай хуульд цэргийн алба хаах хугацаа 12 сар (7.1), 18-25 насны эрэгтэйчүүд заавал цэргийн алба хаахаар (12.2) зохицуулсан.

УИХ Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулж, 2021 онд баталсан бөгөөд тус хуулийн 8-р зүйлээр албадан хөдөлмөрийг хориглосон. Тус зүйлийн 8.3.2-т “хугацаат цэргийн алба хаагчийн хийж гүйцэтгэж байгаа цэргийн зориулалттай ажил, үйлчилгээ”, 8.3.5-д “улс орныг батлан хамгаалах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх, гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг нэн даруй арилгахтай холбоотой ажил, үйлчилгээ” албадан хөдөлмөрлүүлэхэд хамаарахгүй гэж тодорхойлсон нь ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 29, 105-р конвенцод нийцэж байна. Гэсэн хэдий ч 2016 онд баталсан Зэвсэгт хүчний тухай хуулийн 3.1.17, 6.2.11, 6.3, 11.1.15, 13.1.13, 18¹.2.6, 18¹.3.8 зэрэг заалтад хугацаат цэргийн алба хаагчийг “улсыг хөгжүүлэх” ажилд татан оролцуулахаар хуульчилсан. Энэ нь өмнө үйлчилж байсан хуулиас илүү өргөжүүлэн зохицуулсан хэрэг бөгөөд олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй зөрчилдөж байна. ХЭҮК-ын 2016 оны судалгааны зөвлөмжид “Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-р зүйл нь МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээний заалттай нийцэхгүй байгаа тул өөрчлөх” гэсэн байсан бол 2016 оны хуулиар илүү өргөтгөн зохицуулж, нийт 7 заалтаар зэвсэгт хүчнийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцуулахаар заасан.

Цэргийн алба хаагчийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, шийдвэрийг хүснэгт 4, 5-д, цэргийн алба хаагч болон хугацаат цэргийн алба хаагчийн хөдөлмөрт хамааралтай бусад шийдвэрийг хүснэгт 6,7-д харуулсан болно.

► **Хүснэгт 4. Зэвсэгт хүчний тухай хууль, 2002 болон 2016 он:**
Улсыг хөгжүүлэх болон бүтээн байгуулалтын ажилд
зэвсэгт хүчнийг оролцуулах талаарх холбогдох заалт

Зэвсэгт хүчний тухай хууль, 2002 он		Зэвсэгт хүчний тухай хууль, 2016 он	
Зүйл	Агуулга	Зүйл ¹	Агуулга
4.3	Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрөл, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр цэргийн зарим анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.	3.1.17	“барилга-инженерийн цэрэг” гэж улсын онц чухал объект, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын барилга, инженерийн байгууламжийг барих, сэргээн засварлах, дайн байлдааны болон гамшгийн дараах сэргээн босгох, дотоод, гадаадад хүмүүнлэгийн тусламж, энхийг дэмжих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргийн хүчнийг.
		6.2.11	бүтээн байгуулалтын ажилд оролцох
		6.3	Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.
		11.1.15	зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох.
		13.1.13	улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.
		181.2.6	улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон ашиг;
		181.3.8	улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцох анги, салбар, нэгжийн бэлтгэлийг хангах.

Тэмдэглэл: ¹ Энэ заалтуудыг 2020 оны 5-р сарын 14, 2021 оны 1-р сарын 29-ний өдрийн хуулиар тус тус нэмсэн.

Мөн хүснэгт 5-д харуулсан 3 бодлогын баримт бичигт улсыг хөгжүүлэх төсөлд хугацаат цэргийн алба хаагчийн хөдөлмөрийг оролцуулахаар тусгасан байна.

► Хүснэгт 5. Бодлогын бусад баримт, бичиг

№	Эрх зүйн актын нэр	Агуулга
1	Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, УИХ-ын 85-р тогтоол, 2015	8.2.9. улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх
2	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, УИХ-ын 23-р тогтоол, 2020	7.1.3. энхийг дэмжих ажиллагаа болон улс орны стратегийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.
3	Алсын хараа 2050, УИХ-ын 52-р тогтоол, 2020	7.1(4). Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаа болон улс орны бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.

► Хүснэгт 6. Хугацаат цэргийн алба хаагч болон офицер, ахлагчийн хөдөлмөрт хамааралтай хууль

№	Хуулийн нэр	Баталсан он
1.	Батлан хамгаалах тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/12122	2016 он
2.	Зэвсэгт хүчний тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/12123	2016 он
3.	Цэргийн албаны тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124	2016 он
4.	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail?lawId=12125	2016 он
5.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/576	1994 он
6.	Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/578	2002 он
7.	Хөдөлмөрийн тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751	2021 он
8.	Төрийн албаны тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail?lawId=13025	2017 он
9.	Төрийн болон албаны нууцын тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/12408	2016 он
10.	Байгууллагын нууцын тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/102	1995

► **Хүснэгт 7. Хугацаат цэргийн алба хаагч болон офицер, ахлагчийн хөдөлмөрт хамааралтай журам**

№	Журмын нэр	Баталсан он
1.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, УИХ-ын 2020 оны 23-р тогтоол, https://legalinfo.mn/mn/detail/15584	2020
2.	Алсын хараа 2050, УИХ-ын 2020 оны 52-р тогтоол, https://legalinfo.mn/mn/detail/15406	2020
3.	Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, УИХ-ын 2015 оны 85-р тогтоол, https://legalinfo.mn/mn/detail/11382	2015
4.	МУ-ын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлиг, Монгол цэргийн нийтлэг дүрмүүд, http://www.internal-troops.police.gov.mn/media/huuli/tsereg_durem.pdf	2019
5.	МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 208 дугаар зарлиг, Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам	2021
6.	ЗГ-ын 2017 оны 247, Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, https://legalinfo.mn/mn/detail/12878/2/208019	2017
7.	ЗГ-ын 2017 оны 246, Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, https://legalinfo.mn/mn/detail/12885/2/208025	2017
8.	ЗГ-ын 2013 оны 107 дугаар тогтоол, Монгол цэрэг бүтээн байгуулалтад хөтөлбөр, https://legalinfo.mn/mn/detail/9124/2/205820	2013
9.	ХНХС, БХС-ын 2020 оны А/70, А/58, Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам, http://mod.gov.mn/wp-content/uploads/2021/01/A70-A58.pdf	2020
10.	БХС-ын 2021 оны А/62 тоот тушаал, Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө батлах тухай, http://mod.gov.mn/wp-content/uploads/2021/12/A-62.pdf	2021
11.	Батлан хамгаалахын сайд, Сангийн сайдын 2020 оны А/39/28 хамтарсан тушаал, Бүтээн байгуулалтын ажилд оролцуулах бие бүрэлдэхүүний ажлын хөлс, томилолтын зардал, техник хэрэгслийн ашиглалтын төлбөрийг тогтоох тухай	2020
12.	Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2022 оны А/466 дугаар тушаал, Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийг аж ахуйн ажилд оролцуулах үеийн жишиг норм батлах тухай	2022

Зэвсэгт хүчний тухай хуулийн 18-р зүйлийн 18¹.2.6-т “улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон ашиг” нь Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлогыг нэмэх нэг эх үүсвэр байхаар тусгасан нь хугацаат цэргийн алба хаагчийн хөдөлмөрийг улс орны зэвсэгт хүчний өмнө тулгамдаад буй асуудлыг шийдэх нэг гарц гэж харж байгааг илтгэнэ.¹¹ Хууль зүйн судалгааны төвөөс 2021 онд Зэвсэгт хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайланд “2020 оны хаврын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд олон чухал нэмэлт, өөрчлөлтүүдийг

11 Зэвсэгт хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, Хууль зүйн судалгааны төв, 2021 он, 24-25-р тал

оруулсан нь улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох оролцоог төр өөрийн нэгдмэл бодлогоор зохион байгуулж, уялдуулан зохицуулсан гэж ойлгож болох юм”¹² гэсэн дүгнэлт хийжээ. Тус дүгнэлтээс үзэхэд хугацаат цэргийн алба хаагчийг улсыг бүтээн байгуулах ажилд оролцуулах нь хэвийн зүйл болсныг илтгэнэ. Ийнхүү өргөтгөн зохицуулсан нь ОУХБ-ын 105 дугаар конвенцын 1 дүгээр зүйлийн (b) дурдсан эдийн засгийн хөгжүүлэх зорилгоор ажиллах хүчийг дайчлах, ашиглах арга хэлбэр болгох гэсэнтэй зөрчилдөхөөр байна.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.15-д “зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох” үүргийг Монгол Улсын Ерөнхийлөгч хүлээсэн. Нийгмийн сүлжээнд тавигдсан мэдээллээс үзэхэд тус журмыг 2021 онд баталсан байх хэдий ч энэ нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тавигдаагүй байна. Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлд захиргааны хэм хэмжээний актын хүчин төгөлдөр болох нөхцөлийг заасан байдаг бөгөөд аливаа захиргааны хэм хэмжээний акт нь бүрэн эхээрээ “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдэж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудсанд байршсан байх ёстой. Үүний зэрэгцээ өмнө үйлчилж байсан хэм хэмжээний актыг хүчингүй болгох байтал МУ-ын Ерөнхийлөгчийн 1999 оны 153 дугаар зарлигаар баталсан журам эрх зүйн мэдээллийн системд хүчин төгөлдөр байгаа нь зохицуулалтын давхардал үүсгэхээр байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 208 дугаар зарлигаар Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журмыг судалгааны ярилцлагын явцад олж дүгнэлт хийлээ. Тус журмаар цэргийн алба хаагчийн оролцох ажлыг бүтээн байгуулалт, аж ахуйн ажил гэж заагласныг хүснэгт 8-д харууллаа.

► **Хүснэгт 8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 208 дугаар зарлиг:
“Бүтээн байгуулалт”, “аж ахуйн ажил”-ын тодорхойлолт**


Зүйл заалт	Агуулга
2.1.1	“Бүтээн байгуулалт” гэж улсыг хөгжүүлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрлэл, дэд бүтэц, барилга байгууламж барих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цэргийн дэд бүтцийг хөгжүүлэх, улсын болон цэргийн онц чухал объектуудыг барьж байгуулах, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, инновацын судалгаа, туршилт, үйлдвэрлэл, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, экосистемийг сэргээн босгох үйл ажиллагааг;
2.1.2	“Аж ахуйн ажил” гэж Монгол Улсын төрийн ба хувийн хэвшлийн зам, тээвэр, барилга, эрчим хүч, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

12 Зэвсэгт хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, 29-р тал

Журмын 2.1.2 нь ОУХБ-ын албадан хөдөлмөрийн устгах конвенцуудад нийцэхгүй байна. Мөн тус журмын 2.1.1-д заасан “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, экосистемийг сэргээн босгох”, “улсын онц чухал объект”, “стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрлэл, дэд бүтэц, барилга байгууламж” гэх хэсгүүд нь цэвэр цэргийн шинжтэй хөдөлмөр эсэхийг нягтлах шаардлагатай. Энэ нь ОУХБ-ын 105-р конвенцын 1(b) зүйлийг зөрчсөн байх магадлалтай байна. ХЭҮК-ын зөвлөмжид МУ-ын Ерөнхийлөгчийн 153 дугаар зарлигаар баталсан “Цэргийн анги байгууллагыг аж ахуйн ажилд татан оролцуулах журам”-ын 2 дугаар зүйлийг ОУХБ-ын 29 болон 105 дугаар конвенцын шаардлагад нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулахыг тусгасан ч, тус журмыг 2021 онд 208 дугаар зарлигаар шинэчлэн батлахдаа ХЭҮК-ын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд зэвсэгт хүчнийг бүтээн байгуулалт, аж ахуйн ажилд оролцуулах нь үргэлжилсээр байна.

Зэвсэгт хүчнийг аж ахуйн ажилд хэрхэн оролцуулах дарааллыг зураг 1-д үзүүлээ.

► **Зураг 1. Зэвсэгт хүчнийг аж ахуйн ажилд оролцуулах**



ХЭҮК-ын судалгааны зөвлөмжид Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2010 оны 512 дугаар тушаалыг хүчингүй болгох асуудал туссан ч энэ тушаал хүчингүй болсон эсэх мэдээлэл эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байхгүй байсан тул биелсэн эсэхийг мэдэх боломжгүй байна. Гэвч бүтээн байгуулалт, аж ахуйн ажилд оролцуулахтай холбоотой 2 шийдвэрийг судалгааны ажлын явцад олж судалсан бөгөөд эндээс дүгнэхэд дээрх 512 дугаар тушаал үйлчлэхгүй байхаар байна. Батлан хамгаалах сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны А/39/28 тушаалаар бүтээн байгуулалтад оролцож буй Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд олгох хоногийн томилолтын зардлыг 70,000 хүртэл төгрөг байхаар тогтоосон байна. Харин цэргийн алба хаагчийг аж ахуйн ажилд

оролцуулж байгаатай холбоотойгоор ЗХЖШ-ын даргын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийг аж ахуйн ажилд оролцуулах үеийн жишиг норм батлах тухай 2022 оны А/466 дугаар тушаалын 2-р хавсралтаар цалингийн зардлын нэгдсэн товчоог баталсан. Энэ тушаалаар хугацаат цэргийн алба хаагчид аж ахуйн ажилд оролцсон хөдөлмөрийн хөлсийг өдөрт 13,894.10 төгрөг байхаар тогтоосон нь 2023 оны ХХДХ-ний өдрийн өртгөөс бараг 2 дахин бага дүн юм. Энэ 2 шийдвэрийг үзвэл Ерөнхийлөгчийн 208-р зарлигаар баталсан журмын 2.1.1-д заасан ажилд оролцсон цэргийн алба хаагчид 70,000 хүртэл төгрөг олгохоор, 2.1.2-т заасан ажилд оролцвол 13,894.10 төгрөг авахаар байна гэж дүгнэхээр байна.

Дээрх 2 тушаал нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д зааснаар захиргааны хэм хэмжээний акт байх тул хуулиар тусгайлан эрх олгогдсон байх ёстой бөгөөд үндэслэл болгосон эрх зүйн үндэслэлд тусгайлан эрх олгосон хуулийн заалт байхгүй байгаа, мөн эдгээр тушаал нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тавигдаагүй зэргээс үүдэн хүчин төгөлдөр захиргааны хэм хэмжээний акт гэж үзэх боломжгүй болж байна.

3.3. Хугацаат цэргийн алба хаагчийн цэргийн бус хөдөлмөр

ОУХБ-ын 105 дугаар конвенцод хугацаат цэргийн албан хаагчдыг эдийн засгийн хөгжлийн зориулалтаар дайчлахыг албадан хөдөлмөр гэж үздэг болно. Гэвч сүүлийн үед хугацаат цэргийн албан хаагчдын бүтээн байгуулалтын ажилд дайчлах нь жишиг болоод байгаа юм. 2022 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн Засгийн Газрын хуралдаанаар барилгын цэргийн бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад оролцуулах шийдвэрийг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргасан байна.¹³ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих ажилд барилга инженерийн цэргийн есөн ангийн 2,200 гаруй цэргийн албан хаагчид оролцсон байна.¹⁴ Мөн түүнчлэн хугацаат цэргийн албан хаагчид Дарханы замд 17.5 километр хүнд даацын зам, ажилчдад зориулсан байшин барих, гүүр барих гэх мэт бусад төрлийн барилгын төслүүд дээр ажиллажээ.

Барилга инженерийн ангиудын алба хаагчид цэргийн шинжтэй ажил хийгээгүй үедээ цэргийн бус ажилд дайчлагддаг талаар зөвхөн ам дамжсан мэдээлэл байдаг. Харин барилга инженерийн ангиудаас бусад цэргийн ангиудын (016,

¹³ <https://ikon.mn/n/2foz>.

¹⁴ Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын ярилцлага: <http://time.mn/sAs.html>. 3.1.2 дэд бүлгийг харна уу.

0151,¹⁵ 167,¹⁶ 336¹⁷) алба хаагчид цэргийн ангиасаа гадуур барилгын ажил хийсэн тухай мэдээллийн эх сурвалжууд байгаа юм. Мөн цэргийн алба хаагчид ургац, ногоо хураах, мод тарих зэрэг ажилд нэлээд оролцдог байна. Тухайлбал Монгол Улсын Зэвсэгт Хүч (МУЗХ)-ний вэбсайтад 150 дугаар цэргийн анги 150 мод тарьсан тухай мэдээлэл байна.¹⁸

Хугацаат цэргийн алба хаагчид цэргийн бус ажил хийсэн хөлснийхөө зарим хэсгийг өөрсдөө авдаг байна. Zarig.mn сайтын сурвалжлагч Өнөрцэцэг хугацаат цэргийн алба хаагчид өдрийн 50,000 төгрөгийн цалин авдагас 40,000 төгрөгийг нь цэргийн анги авч 10,000 төгрөгийг нь алба хаагч өөрөө авдаг тухай мэдээлжээ.¹⁹ Мөн түүнчлэн цэргийн алба хаагчид ажил хийх үеэрээ ноцтой гэмтэж бэртдэг ихэнх мэдээллийн эх сурвалжууд бичиж байгаагаас цэргийн бус ажлын нөхцөл муу байдаг гэж дүгнэж болохоор байна.²⁰

3.4. Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцын талаарх мэдлэг

Монгол Улс ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцыг 2005 онд соёрхон баталсан. Эдгээр конвенцуудын орчуулгыг *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2005, No 9:390)-д нийтэлжээ. Харин Төрийн мэдээлэл эмхэтгэлийг маш цөөхнөөр хэвлэж тараадаг бөгөөд саяхнаас цахимаар унших боломжтой болгожээ. Тиймээс эдгээр конвенцуудын орчуулгыг нийтэлсэн эмхэтгэлийн дугаар, оныг нарийн мэдэхгүйгээр олоход хүндрэлтэй байна. Монгол Улсад бүх хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ, олон улсын гэрээг хууль эрх зүйн нэгдсэн платформд (www.legalinfo.mn) байршуулахыг шаарддаг бөгөөд энэ нь улсын хэмжээнд хамгийн өргөн хэрэглэгддэг эрх зүйн эх сурвалж юм. Гэсэн хэдий ч одоогоор энэхүү нэгдсэн системээс 29, 105 дугаар конвенцуудын эхийг авч ашиглах боломжгүй, зөвхөн эдгээр конвенцуудыг соёрхон батлах тухай хуулийн тогтоолуудыг харах боломжтой. Гадаад харилцааны яамны вэбсайтад Англи хэл дээрх эхүүд байгаа ч Монгол хэл дээрх орчуулсан хувилбар байхгүй байгаа нь конвенцуудын талаарх мэдлэг дутмаг байгаад нөлөөлж байж болох бөгөөд асуудлыг шийдвэрлэхийн тулд эдгээр конвенцуудын Монгол орчуулгыг эрх зүйн нэгдсэн системд нэмж оруулах хүсэлтийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлнэ. Ингэснээр конвенцуудтай танилцаж, хэрэглэх нь хялбар болсноор эдгээрийн хэрэглээг Монгол Улсад нэмэгдүүлнэ гэж найдаж байна.

¹⁵ <http://www.zaluu.mn/p/34425.html>.

¹⁶ <https://mongoltur.mn/25857.html/>.

¹⁷ <http://www.bolod.mn/News/124260.html>.

¹⁸ <https://qsmaf.gov.mn/th/onePost/102>.

¹⁹ <https://twitter.com/unurtsetsegn/status/1548999010265939968?lang=gu>.

²⁰ <https://zarig.mn/yy3>.

► 4. Үр дүн

4.1. Тоон судалгаа

Хоёр төрлийн тоон судалгаа хийсэн: нэг нь хугацаат цэргийн алба хааж байгаа цэргийн (4 цэргийн ангийн 202 цэрэг) судалгаа, нөгөө нь хугацаат цэргийн албанаас халагдсан цэргийн (100 иргэн) судалгаа. Хугацаат цэргийн алба хаагчийн судалгаанаас давхардсан мэдээллийг хассанаар ажиглалтын тоо 192 болж буурсан.

4.1.1. Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаа

Улаанбаатар хот, Өвөрхангай, Баянхонгор аймгийн цэргийн дөрвөн анги, үүнээс хоёр барилга инженерийн ангийн хугацаат цэргийн алба хаагчдыг судалгаанд хамруулсан. Хүснэгт 9 ярилцлагад хамрагдсан хугацаат цэргийн алба хаагчдын шинж чанарыг харуулж байна: хугацаат цэргийн алба хаагчид ихэвчлэн хөдөө орон нутгийн (81 хувь), шашин шүтлэггүй (66 хувь), Монголын зонхилох үндэстэн болох Халх (90 хувь) байна; Тэдний 73 хувь нь цэргийн ангиудад өөрсдийн хүсэлтээр хуваарилагдсан.

► Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан цэргийн алба хаагчдын шинж чанар

	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн бага	Хамгийн их
Барилга инженерийн анги	0.56	0.5	0	1
Нас	20.23	1.79	18	27
Халх (Монголд зонхилох үндэстэн)	0.9	0.31	0	1
Оршин суугаа газар: Хөдөө	0.81	0.39	0	1
Бүрэн дунд эсвэл түүнээс дээш боловсролтой	0.8 2	0.3 9	0	1
Шашин шүтлэггүй	0.66	0.48	0	1
2022 онд цэрэгт татагдсан	0.98	0.12	0	1
Өөрийн хүсэлтээр томилогдсон	0.73	0.44	0	1
Ажиглалтын тоо				192

Эх сурвалж: Хугацаат цэргийн алба хаагчдын судалгааны тоон өгөгдөл.

4.1.2. Халагдсан цэргийн судалгаа

Судалгаанд 2010-2022 оны хооронд цэргийн алба хаасан 100 иргэн хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын 74 хувь нь 2019-22 онд цэргийн албаа хаасан байна. Судалгаа Улаанбаатар хот болон 15 аймгийн иргэдийг хамруулсан; судалгаанд оролцогчдын тал нь Улаанбаатар хотын оршин суугчид байна.

► Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан халагдсан цэргийн шинж чанар

	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн бага	Хамгийн их
Нас	22.97	3.23	19	33
Халх (Монголд зонхилох үндэстэн)	0.89	0.31	0	1
Оршин суугаа газар: Хөдөө	0.51	0.5	0	1
Бүрэн дунд эсвэл түүнээс дээш боловсролтой	0.96	0.20	0	1
Шашин шүтлэггүй	0.86	0.35	0	1
2022 онд цэрэгт татагдсан	0.22	0.42	0	1
Өөрийн хүсэлтээр томилогдсон	0.56	0.5	0	1
Ажиглалтын тоо	100			

Эх сурвалж: Хугацаат цэргийн алба хаасан хүмүүсийн судалгааны тоон өгөгдөл.

Хүснэгт 10 судалгаанд оролцогчдын шинж чанарыг харуулж байна. Халагдсан цэргүүд нь хугацаат цэргийн алба хаагчдаас арай өндөр боловсролтой, насаар арай ахмад байсан. Халагдсан цэргийн судалгаанд хамрагдагсад ихэвчлэн шашин шүтлэггүй (86 хувь) ба яс үндэс халх (89 хувь) байна. Тэдний 56 хувь нь цэргийн ангиудад өөрсдийн хүсэлтээр хуваарилагджээ.

4.2. Хугацаат цэргийн алба хаагчдын эрхэлдэг ажлын төрлүүд

Тайлангийн энэ хэсэгт хугацаат цэргийн алба хаагчид болон халагдсан цэргүүдийн дунд хийсэн түүвэр судалгаануудын үр дүнгээс танилцуулна.

Хугацаат цэргийн алба хаагчдын дийлэнх буюу 59% нь нэг төрлийн ажил хийсэн гэж мэдээлсэн бол 26% нь хоёр төрлийн ажил, 11% нь гурван төрлийн ажил хийсэн байна. Улмаар тэдний 49% нь нэг төрлийн, 23% нь хоёр төрлийн, 5.2% нь гурван төрлийн цэргийн шинжтэй хөдөлмөр эрхэлсэн байна. Судалгаанд хамрагдсан хугацаат цэргийн алба хаагчдын 64% нь ямар нэг цэргийн бус хөдөлмөр эрхлээгүй гэсэн бол 30% нь нэг төрлийн, 5.3% нь хоёр төрлийн цэргийн бус хөдөлмөр эрхэлсэн байна.


Эрхэлсэн ажлын тоог хугацаат цэргийн алба хаагчид болон дийлэнх нь 2018 оноос 2022 онд алба хаасан халагдсан цэргүүдтэй харьцуулахад нэлээд ялгаатай байгаа нь ажиглагдсан (Зураг 2). Судалгаа авах үед албаа хааж байсан хугацаат цэргийн алба хаагчдын 36% нь цэргийн бус хөдөлмөр эрхэлсэн бол халагдсан цэргүүдийн 94% нь ийм төрлийн хөдөлмөр эрхэлсэн байв. Харин халагдсан цэргүүдийн 60 гаруй хувь нь цэргийн шинжтэй хөдөлмөр эрхэлсэн бол хугацаат цэргийн алба хаагчдын 78% нь ийм төрлийн хөдөлмөр эрхэлсэн гэж хариулжээ.

Хугацаат цэргийн алба хаагчид сарын 100,000 төгрөгийн цалинтай гэж мэдээлсэн бол зарим халагдсан цэргүүдийн сарын цалин 70,000 төгрөг байжээ. Үүнээс харахад хугацаат цэргийн алба хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Цэргийн алба хаагчид болон халагдсан цэргүүдтэй хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагаас цэргүүдийн үндсэн бэлтгэл, сургалт зургаан сарын хугацаанд үргэлжилдэг гэж дүгнэхээр байв. Зарим судалгаанд оролцогчид цэргүүдийн үндсэн бэлтгэл сургалтад сэтгэл дундуур байдаг тухайгаа илэрхийлж байсан юм. Нэлээд хэдэн цэргийн алба хаагчид одоогийн цэрэг, армийн бэлтгэл, сургалт хангалтгүй бөгөөд хугацаат цэргийн алба хаагчдаар цэргийн бус хөдөлмөр эрхлүүлж цаг хугацааг нь дэмий үрж буйд шүүмжлэлтэй хандаж байв. Зарим халагдсан цэргүүдийн энэ талаар өгсөн ярилцлагууд:

"Миний бие армид алба хаахаасаа өмнө их сургуулиа төгссөн байсан. Намайг армид очоод удаагүй байхад компьютерт сайн гэдгийг офицерууд мэдээд надаар баримт бичиг шивүүлэх ажил хийлгэсэн. Шивүүлсэн зүйл нь цэргийн бэлтгэл, сургалтын хичээлийн хөтөлбөр байсан. Тэр сургалтын хөтөлбөр надад их өндөр сэтгэгдэл төрүүлсэн. Учир нь тэр хөтөлбөр нь нэлээн нарийвчилсан төлөвлөгөөтэй бөгөөд олон төрлийн мундаг ур чадварууд заахаар тусгасан байв. Тухайлбал, усгүй газар хэрхэн амьд үлдэх, хээр газар цэргийн хүрмээ хэрхэн үр ашигтай ашиглах тухай гэх мэт зүйлс байсан. Гэвч намайг алба хаах хугацаанд тэр хөтөлбөрт бичигдсэн зүйлсээс нэгийг нь ч заагаагүй, дадлага хийгээгүй. Бэлтгэл сургалт гэвэл өглөө бүр гүйдэг байсан. Долоо хоногтоо нэг удаа буу задлах угсрахыг хийдэг байсан. Энэ нь бууг долоо хоног бүр цэвэрлэх шаардлагатай болохоор л хийлгэдэг байсан юм шиг санагдсан."


"Би цэргийн алба хаагч юм уу цагдаагийн алба хаагч болох хүсэлтэй байсан учраас армид явсан. Гэвч би амьдралынхаа нэг жилийг армид дэмий үрсэн. Нийтдээ таван сарын хугацаанд би ургац, ногоо хураах ажил хийсэн. Цэргийн бэлтгэл, сургалт гэж бараг хийгээгүй. Энэ төрлийн бэлтгэл гэвэл өглөө бүр гүйх, буу задалж угсрахыг л хийсэн."

► **Зураг 2. Хугацаат цэргийн алба хаагчийн эрхэлсэн ажлын төрлүүдийн тоо**

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд зааснаар “барилга-инженерийн цэрэг” нь Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын барилга, инженерийн байгууламжийг барих, сэргээн засварлах, дайн байлдааны болон гамшгийн дараах сэргээн босгох, дотоод, гадаадад хүмүүнлэгийн тусламж, энхийг дэмжих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргийн хүчнийг хэлнэ.


Судалгаанд барилга инженерийн хоёр цэргийн ангийн хугацаат цэргийн алба хаагчид болон цэргийн алба хаагчид хамрагдсан. Түүвэр судалгаанд оролцогчдын 56 хувийг барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчид эзэлж байна.

► **Зураг 3. Хугацаат цэргийн алба хаагч эрхэлсэн ажлын төрлүүдийн тоо: барилга инженерийн ба бусад цэргийн анги**



Зураг 3-т хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн болон цэргийн бус ажлын төрлүүдийн тоог энгийн болон барилга инженерийн цэргийн ангиар ялган харуулж байна. Судалгаанд хамрагдсан барилга инженерийн цэргийн ангийн хугацаат цэргийн алба хаагчдын 71% нь цэргийн бус ажилд оролцоогүй гэсэн бол бусад ангийн хувьд энэ нь 55.3% байна. Харин барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчдын 28%, бусад алба хаагчдын 15.3% нь ямар нэг цэргийн шинжтэй ажил хийгээгүй гэжээ.

Цэргийн бус ажлын төрлүүд барилга инженерийн болон бусад алба хаагчдын хувьд ялгаатай байгаа нь зураг 4-өөс харагдаж байна. Ядаж нэг цэргийн бус ажил хийсэн гэж хариулсан барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчид нийтийн зориулалттай барилга байгууламж (14%), барилгын материал үйлдвэрлэл (6.5%), мод бэлтгэх, боловсруулах (5.6%) болон ургац, ногоо хураалт (2.8%) зэрэг ажил хийсэн байна.

► **Зураг 4. Цэргийн болон цэргийн бус хөдөлмөр, сургалт, цэргийн анги, нэгтгэлээр**

Зураг 4-өөс харахад бусад ангийн алба хаагчдын хувьд ургац, ногоо хураалтын ажил (38.6%) хийх нь хамгийн түгээмэл байхад барилга инженерийн цэргийн ангийн хувьд энэ нь 2.8% байгаа юм. Барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчдын хувьд барилга, байгууламж дээр илүүтэй ажиллаж байгаа нь анги нэгтгэлийн онцлогтой холбоотой юм. Харин бусад ангитай харьцуулахад барилга инженерийн цэргийн хувьд цэргийн бэлтгэл, сургалт бага хийдэг нь харагдаж байна. Энэ нь барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчид мэргэшил олгох сургалтад хамрагддагтай холбоотой байж болох юм. Учир нь цэргийн алба хаагчид болон хугацаат цэргийн алба хаагчидтай хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр барилга инженерийн цэргийн ангийн цэргүүд алба хаах хугацаандаа мэргэшил олгох сургалтад хамрагдаж, гэрчилгээ авдаг тухай ярьж байсан юм. Бусад ангиудын хувьд жолооны сургалтад хамруулдаг байна.

4.3. Хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн бус хөдөлмөр

Зэвсэгт хүчний тухай хууль (3.1.17, 6.2.11, 6.3, 11.1.15, 13.1.13, 18¹.2.6, ба 18¹.3.8) хугацаат цэргийн алба хаагчийг цэргийн бус ажилд оролцуулах эрх зүйн үндсийг тавьж өгсөн байна. Зэвсэгт хүчний ерөнхий командлагч бүтээн байгуулалтын ажилд тодорхой тооны цэргийн алба хаагчийг оролцуулах зөвшөөрлийг баталдаг. Цэргийн анги, нэгтгэлүүд энэхүү зөвшөөрлийг үндэслэн хугацаат цэргийн алба хаагчийг цэргийн бус ажилд оролцуулдаг бөгөөд Зэвсэгт хүчний жанжин штабын даргын баталсан цалин, хөдөлмөрийн стандартыг мөрддөг.

Хоёр судалгаа аль аль нь хугацаат цэргийн алба хаагчид цэргийн бус ажилд өргөнөөр оролцдог болохыг харуулсан (хүснэгт 11). Хугацаат цэргийн алба хаагчийн судалгаанд оролцогчдын тал орчим нь (41 хувь), халагдсан цэргийн судалгаанд оролцогчид бараг бүгдээрээ (94 хувь) цэргийн бус ажил хийж байсан гэж хариулсан.

► Хүснэгт 11. Цэргийн шинжтэй болон цэргийн бус ажил хийсэн байдал, хувиар


	Цэргийн шинжтэй ажил хийсэн	Цэргийн бус ажил хийсэн
1. Алба хааж буй цэргүүд		
Барилга-Инженерийн анги	72%	36%
Бусад анги	85%	48%
Бүгд	78%	41%
2. Халагдсан цэргүүд		
Бүгд	61%	94%

Эх сурвалж: Цэргийн алба хаагчийн болон цэргийн албанаас халагдсан иргэдийн судалгааны тоон өгөгдөл

4.4. Цэргийн бус ажлын төрлүүд

Хугацаат цэргийн алба хаагчдын дунд хамгийн түгээмэл цэргийн бус ажлууд нь газар тариалан, хүнсний ногоо тарих, хураах ажил байна: хугацаат цэргийн алба хааж байсан хүмүүсийн 61.5 хувь нь, одоогийн цэргийн алба хаагчдын 21.9 хувь нь тариалалт, ургац хураалтад ажилласан байна. Хоёр дахь нийтлэг ажил нь төмөр зам барих, нийтийн барилга байгууламж, барилгын үйлдвэрлэл зэрэг барилгын ажилтай холбоотой ажил юм (Зураг 5).

► Зураг 5. Хугацаат цэргийн алба хаагчдын хийдэг цэргийн бус ажлын төрлүүд, %



Хугацаат цэргийн алба хаагчийн судалгаагаар цэргийн бус ажлын 65 хувь нь цэргийн ангийн нутаг дэвсгэр эсвэл цэргийн ангийн эзэмшил газарт хийгдсэн байна (хүснэгт 12). Халагдсан цэргийн судалгаанд оролцогчдын мэдээлснээр цэргийн бус ажлын 35.9 хувь нь л цэргийн ангийн нутаг дэвсгэр буюу цэргийн ангийн эзэмшил газарт байсан байна. Цэргийн бус ажлын байрны нэлээд хэсэг нь цэргийн анги, цэргийн ангийн баазын гадна байрладаг байна.

► Хүснэгт 12. Цэргийн бус ажлын байршил


	Хугацаат цэргийн алба хаагчийн судалгаа (%)	Халагдсан цэргийн судалгаа (%)
Цэргийн анги, талбай	65.0	35.9
Төрийн өмчит газар	9.8	14.1
Хувийн эзэмшлийн газар	25.0	50.0

Эх сурвалж: Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаа, халагдсан цэргийн судалгааны тоон өгөгдөл.

Судалгаа тус бүрээс гурван хүн л онцгой байдлын улмаас цэргийн бус ажил хийсэн байгаагаас үзэхэд цэргийн бус ажил онцгой байдалтай төдийлөн хамааралгүй байна. Түүнчлэн хугацаат цэргийн алба хааж байгаа хүмүүсийн дийлэнх хувийг дарга нар нь томилдог тул цэргийн бус ажил нь сайн дурын бус байна (Зураг 6): хугацаат цэргийн алба хаагчийн судалгаанд зөвхөн 19.6 хувь нь, халагдсан цэргийн судалгаанд 14.8 хувь нь л цэргийн бус ажилд сайн дураар томилогджээ.

Гэхдээ КЗХХШХ-ны ажиглалтаар (ОУХБ 2007, 45-р зүйл) эдгээр үр дүнг болгоомжтой тайлбарлах хэрэгтэй юм. Хугацаат цэргийн алба хааж байгаа тохиолдолд цэргийн алба хаагчдад цэргийн шинжтэй ажил болон цэргийн бус ажлын аль нэгийг нь сонгох сонголт өгсөн байсан ч заавал гүйцэтгэх албан үүргийн дор ийм сонголт хийдэг тул үүнийг сайн дурынх гэж үзэх боломжгүй юм.

► Зураг 6. Цэргийн бус ажлын сонголт (хувиар)



4.5. Хугацаат цэргийн алба хаагчдын хөдөлмөрийн нөхцөл


Цэргийн алба хаагчид цэргийн бус ажлыг ихэнхдээ ямар нэгэн гэрээ байгуулахгүйгээр хийдэг. Хугацаат цэргийн алба хаагчийн судалгаагаар цэргийн бус ажлын 40 хувь нь амаар болон бичгээр гэрээ байгуулсан бол халагдсан цэргүүдийн ердөө 4.7 хувь нь ямар нэг гэрээтэй ажиллажээ. Энэ үр дүн нь цэргийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үеэр авсан цэргийн бус ажил нь цэргийн ажилтай ижил дүрмийг баримтлах ёстой гэсэн мэдээлэлтэй нийцтэй байгаа юм. Хугацаат цэргийн алба хаагчаар цэргийн бус ажил хийлгэхдээ зөвшөөрөл авах ёстой гэсэн албан ёсны заавар байдаггүй бөгөөд цэргийн ангиуд хугацаат цэргийн алба хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй. Харин ажилд авах байгууллагатай (ихэнхдээ газар тариалангийн чиглэлээр ажилладаг) ажлын цаг, үүрэг даалгавар, техник хэрэгсэл, орон байр, хоол хүнс зэргийг багтаасан гэрээг цэргийн анги байгуулж, хугацаат цэргийн алба хаагчдыг тухайн ажилд томилдог нийтлэг практик байдаг.

Гэрээ байгуулсан хугацаат цэргийн алба хаагчдын мэдээлснээр гэрээ байгуулсан талын 73.3 хувь нь гэрээгээр тохиролцсон нөхцөлөө биелүүлсэн байна. Хэдий тийм боловч, бичгээр хийсэн гэрээний тавны нэг, аман хэлцлийн бараг тал хувь нь ажлын цагийн нөхцөлийг, зарим тохиолдолд гүйцэтгэх ажлын талаарх нөхцөлийг дагаж мөрддөггүй байна.

4.5.1 Цэргийн бус ажлын цалин хөлс

Ярилцлагад хамрагдсан цэргийн мэргэжилтнүүдийн хэлж буйгаар хугацаат цэргийн алба хаагчийн цалин хөлсний хоёр норм байдаг. Цэргийн алба хаагчид барилга, төмөр зам барих зэрэг улсын бүтээн байгуулалтын ажил хийвэл өдрийн хөлс нь 70,000 хүртэл төгрөг, бусад ажлын хувьд өдрийн хөлс нь 13,000 орчим (сард 286 мянга орчим) төгрөг байдаг. Хэдий тийм боловч энэ хоёр судалгаанаас үзэхэд хугацаат цэргийн алба хаагчид цэргийн бус ажлыг цалин хөлсгүй хийх нь түгээмэл байна: хугацаат цэргийн алба хаагчдын 35.9 хувь нь цалин хөлсгүй ажилласан бол, халагдсан цэргүүдийн 78.1 хувь нь цалин хөлсгүй (Зураг 7) ажиллажээ. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон нэг хүний хэлснээр: “Хугацаат цэргийн алба хаагчид тариалалт, ургац хураалт, хивс цэвэрлэх зэрэг ажилд цалин хөлсгүй ажилладаг”.

► **Зураг 7. Цэргийн бус хөдөлмөрийн цалин хөлс**




Цэргийн бус ажлын хөлсийг хоёр хэлбэрээр олгодог: даалгавраа биелүүлсний дараа өдрөөр хөлсийг нь тооцох эсвэл хугацаат цэргийн албанаас халагдсаных нь дараа нэг мөр олгох. 2023 онд Монгол Улсын нэг өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 26,200 (сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,000) төгрөг байсан. Хугацаат цэргийн алба хаагчдын мэдээлсэн цалин хөлс нь үүнээс доогуур бөгөөд ихээхэн ялгаатай байна. Ажил үүргээ гүйцэтгэсний дараах цалинтай ажлын сарын хөлс нь 13,000-аас 750,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд сарын медиан цалин 100,000 төгрөг, сарын дундаж цалин 236,100 төгрөг байна. Судалгаанд оролцсон барилга инженерийн ангийн нэгээс бусад цэргийн алба хаагчдын сарын цалин 540,000 төгрөгөөс дээш байсан бол бусад ангийн цэргийн алба хаагчдын сарын цалин 200,000 төгрөгөөс бага байна. Судалгаанд оролцогчдын мэдээлсэн цалинууд мэргэжилтнүүдийн дээр дурдсан цалингаас хамаагүй бага байна (бусад төрлийн ажлын сарын хөлс багадаа 286,000 төгрөг).

Хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн албанаас халагдсаныхаа дараа авахаар хүлээж буй цалингийн орлого нь 500,000 төгрөгөөс гурван сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Барилга инженерийн ангийн хугацаат цэргийн алба хаагчдын хүлээж буй цалин нь сарын цалингийн нэг адил бусад ангиудынхаас өндөр байна. Цэргийн бус ажлаас цалин авдаг гэж мэдээлсэн хугацаат цэргийн алба хаагчдын дунд ч багагүй хэсэг нь (21.4 хувь) цалингаа ямар байхыг мэдэхгүй байгаа нь анхаарал татаж байна. Хугацаат цэргийн алба хаагчид цэргийн бус ажлын хөлсөө мэдэхгүй байгаа байдал ганцаарчилсан ярилцлагаас ч харагдаж байв.

4.5.2 Ажлын өдөр, цаг

Хугацаат цэргийн алба хаагчид мэдэгдэхүйц урт цагаар ажилладаг байна (зураг 8). Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаагаар цэргийн бус ажлын тал нь өдөрт 8-аас дээш цаг ажиллуулдаг: дундаж ажлын цаг 8.9 бол медиан ажлын цаг 8.5 байна. Халагдсан цэргүүдийн судалгаанаас мөн үүнтэй төстэй үр дүн гарсан: ажлын дундаж цаг 8.7 бол медиан цаг нь 8.0 байв. Зураг 8-аас харахад хугацаат цэргийн алба хаагчдын бараг 30 хувь нь өдөрт 10-аас дээш цаг ажилласан байна.

► **Зураг 8. Цэргийн бус хөдөлмөрт зарцуулсан ажлын цаг**



Хугацаат цэргийн алба хаагчид сард дунджаар 17.3 өдөр ажилласан байна. Гэвч нэлээд олон тооны ажил цэргийн алба хаагчдыг сард 22-оос олон өдөр (долоо хоногт таван өдөр) ажиллуулжээ. Цэргийн бус ажлын бараг тал нь (45.2 хувь) цэргийн алба хаагчдыг сард 24 ба түүнээс дээш ажлын өдөр ажиллуулсан бол 27.4 хувь нь сард 27 ба түүнээс дээш ажлын өдөр ажиллуулсан байна.

Цэргийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар гэрээнд заасан ажлын цаг нь ихэвчлэн өдөрт ажиллах цаг, сард ажиллах өдрийн хуулиар тогтоосон хязгаараас хэтрэхгүй байх ёстой. Гэвч бодит байдал дээр ажлын цаг, ажлын өдрүүд хуулиар тогтоосон хэмжээнээс давдаг болох нь судалгаанаас харагдаж байна. Түүнчлэн, хугацаат цэргийн алба хааж байгаа цэргийн алба хаагчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас харахад зарим үед цэргийн бус ажлын ажлын цаг, ажлын өдөр нь хуулиар тогтоосон хязгаараас хэтэрдэг тохиолдол ч байна.

“Эхэндээ барилгын суурь тавих үе, дараа нь барилгаа хүлээлгэн өгөхөд бэлдэх үеэр амралтын өдрүүдээр амралтгүй ажилласан. Барилгын ажлын дундуур бол бүтэн сайнд амардаг байсан.”

“Ажил өглөөний 08.30 цагт эхэлдэг. Хэлтсийн дарга ажлын хүнд, хөнгөнөөс хамааруулан ажлыг өөрчилж, хуваарилна. Үдийн хоол 13:00 цагт. Өдрийн хоолны дараа амарч 14:00 цагт ажилдаа орно. Оройн 19:00 цагаас оройн хоол идчихээд буцаад 21:00 цаг хүртэл ажилладаг.”

4.5.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал

Зэвсэгт хүчин хугацаат цэргийн алба хаагчид болон зэвсэгт хүчний алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулдаг болохыг зэвсэгт хүчний мэргэжилтнүүд онцолж байна. Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмаар зэвсэгт хүчний анги, нэгтгэл, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цалинтай, орон тооны албан тушаалтан ажиллуулах ёстой. Барилга инженерийн ангийн удирдах газраас хөдөлмөрийн аюулгүй байдлын офицер бэлтгэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг ба ажил үүрэг гүйцэтгэхээр томилогдсон жижиг нэгж бүрийг хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтнээр хангах зорилготой.

Ажил үүрэг гүйцэтгэх тохиолдол бүрд харгалзах хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн бэлтгэж, ангийн дарга батална. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабаас санхүү, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулдаг. Цэргийн алба хаагчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байгаа офицерууд өглөө бүр ажил эхлэхийн өмнө цэргийн алба хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, цэргийн алба хаагчид уг зааварчилгаатай танилцан гарын үсэг зурдаг ба амны хаалт, бээлий, хамгаалалтын малгай зэрэг хэрэглэгдэхүүнийг хүлээж авдаг. Судалгаанд хамрагдсан цэргийн алба хаагчдын мэдээлснээр ноцтой гэмтэл гарч байгаагүй байна. Нэг ярилцлагын үеэр барилгын ажлын үеэр нэг цэргийн алба хаагч өндрөөс унаж, хөлдөө хөнгөн гэмтэл авсан талаар дурдсан; өөр нэг ярилцлагад хугацаат цэргийн алба хаагч эрүүл мэндийн үзлэгт орохдоо шархаа нууснаас болж хүндэрсэн талаар дурдсан. Түүнчлэн, гар цэврүүтэх, хуруугаа хөнгөн зүсэх зэрэг тохиолдлууд гардаг ба иймэрхүү хөнгөн гэмтэл гарахад хариуцсан офицер, алба хаагчид анхны тусламж үзүүлдэг байна.

“Би сүүлийн таван сарын хугацаанд тасралтгүй ажилласан. Янз бүрийн зориулалтаар нүх ухах болон ургац хураах ажил хийсэн. Гар цэврүүтэх зэрэг хөнгөн гэмтэл гардаг ч, ажлын явцад ноцтой бэртэл гэмтэл гараагүй.”

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны экспертийн мэдээлснээр Засгийн газраас хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналтыг нэгдсэн бодлогоор бүхий л хүрээнд тухайлбал, зэвсэгт хүчний анги, байгууллагыг хамруулан хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ бодлогын хүрээнд хөндлөнгийн мэргэжилтнүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалт хийх тул үйлдвэрлэлийн осол гэмтлийг улсын хэмжээнд бүрэн бүртгэж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах боломжтой.

4.6. Сургалт

Судалгааны асуумжаар хугацаат цэргийн алба хаагчдын эрхэлсэн хөдөлмөр нь мэргэшил олгох сургалтын хүрээнд байсан эсэхийг тодруулсан. Судалгаанд хамрагдсан 192 хугацаат цэргийн алба хаагчдын 71 (37%) нь цэргийн бус хөдөлмөр эрхэлсэн гэж хариулсан байна. 33 (17.2%) хугацаат цэргийн алба хаагчийн хувьд цэргийн бус ажлыг мэргэшил олгох сургалтын хүрээнд хийсэн гэсэн бол үлдсэн 38 (19.8%) алба хаагчийн хийсэн цэргийн бус ажил нь ямар нэг мэргэшил олгох сургалтын хүрээнд хийгдээгүй байв. Цэргийн бус ажлыг мэргэшил олгох сургалтын хүрээнд хийсэн гэж хариулсан цэргүүд бүгд өөрсдийн хүсэлтээр сургалтад хамрагдсан гэж хариулсан. Гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр мэргэшил олгох сургалтыг ихэвчлэн барилга инженерийн цэргийн ангийн цэргүүдэд санал болгодог бөгөөд өөрсдийнх саналыг харгалздаг болох нь ажиглагдсан.

Цэргийн бус хөдөлмөр эрхлэлт нь мэргэшил олгох сургалттай холбоотой эсэх дээр барилга инженерийн болон бусад ангиудын хооронд нэлээд их ялгаа байна. Хүснэгт 13-аас харахад барилга инженерийн ангийн цэргүүдийн 21.5 хувь нь цэргийн бус ажлыг мэргэшил олгох сургалтын хүрээнд хийсэн бол бусад ангиудын хувьд 9.4 хувь нь хийсэн байна. Өмнөх хэсэгт зарим хугацаат цэргийн алба хаагчид нэгээс олон төрлийн цэргийн бус ажил эрхэлсэн болохыг харуулсан. Барилга инженерийн цэргийн алба хаагчдын 16.8 хувь нь нэг төрлийн цэргийн бус ажлыг мэргэшил олгох сургалтын хүрээнд хийсэн бол бусад ангийн алба хаагчдын 8.2 хувь нь нэг төрлийн цэргийн бус ажлыг мэргэшил олгох сургалтын хүрээнд хийсэн гэжээ.

► Хүснэгт 13. Мэргэшил олгох сургалт, цэргийн ангиар

	Барилга инженерийн цэргийн анги (%)	Бусад анги (%)	Нийт (%)
Цэргийн бус ажил нь мэргэшил олгох сургалтын хэсэг болох	21.5	9.4	17.2
Цэргийн бус ажил нь мэргэшил олгох сургалттай холбоогүй	7.5	35.3	19.8


Мэргэшил олгох сургалтад хамрагдалт Улаанбаатарт байрладаг цэргийн ангиуд болон орон нутагт байрладаг цэргийн ангиудаар ялгаатай байна. Улаанбаатарт байрладаг барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчдын 37.3 хувь цэргийн бус ажил нь мэргэшил олгох сургалттай холбоотой гэж хариулсан бол орон нутагт байрладаг барилга инженерийн цэргийн ангийн алба хаагчдын 7.1 хувь ингэж хариулжээ.

Зураг 9, 10-т цэргийн бус хөдөлмөр эрхэлсэн гэж хариулсан нийт цэргүүдийн тоог уг ажил нь мэргэшил олгох сургалттай холбоотой байсан гэж хариулсан тоотой харьцуулан харуулж байна. Эдгээр хариултууд цэргийн бус ажлын төрөл болон цэргийн анги, нэгтгэлээс хамааран нэлээд ялгаатай байгаа нь зургуудаас харагдаж байна. Барилга инженерийн цэргийн ангийн цэргүүд барилга, байгууламж дээр илүүтэй ажилладаг бөгөөд эдгээр ажлууд нь мэргэшил олгох сургалттай холбоотой байх нь түгээмэл байгаа юм. Мэргэшил олгох сургалтууд нь барилгын засал, чимэглэл, гагнуурчин, цахилгаанчин, болон мужаан гэх мэт мэргэшлийн зэрэг олгодог байна.

► **Зураг 9. Барилга инженерийн ангид хугацаат цэргийн алба хаагчдын мэргэшил олгох сургалтаар хийсэн цэргийн бус хөдөлмөр**



► **Зураг 10. Бусад алба хаагчдын мэргэшил олгох сургалтаар хийсэн цэргийн бус хөдөлмөр**



Судалгаанд хамрагдсан 100 халагдсан цэргүүдийн ердөө гурав нь алба хаах хугацаандаа хийсэн цэргийн бус ажил нь мэргэшил олгох сургалттай холбоотой байсан гэжээ. Эзэмшсэн мэргэшил нь цахилгаанчин, гар урлал, болон барилгын засал чимэглэл гэсэн байна. Гүнзгийрүүлсэн ярилцлага өгсөн халагдсан цэргүүдээс нэг нь ч мэргэшил олгох сургалтад хамрагдаагүй байсан. Харин ярилцлагуудаас жолооны сургалт маш түгээмэл бөгөөд цэргийн алба хаагчид энэ сургалтад хамрагдах хүсэлтэй байдаг нь ажиглагдсан.

4.7. Онцгой байдал

Судалгаанаас харахад хугацаат цэргийн алба хаагчаар онцгой байдлын үед цэргийн бус хөдөлмөр хийлгэх нь харьцангуй цөөн байна. Үер, зуд, болон COVID-19-тэй холбоотой онцгой байдлын үеэр яаралтай ажилд хамрагдсан зургаан тохиолдол (хугацаат цэргийн алба хаагчдын судалгаанд гурав, халагдсан цэргийн судалгаанд гурав) бүртгэгдсэн байна.²¹

Хугацаат цэргийн алба хаагчдын судалгаанд дурдагдсан онцгой байдал нь үер, зудтай холбоотой байсан. Зудын үеэр нэг хугацаат цэргийн алба хаагч 2023 оны дөрөвдүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн цэргийн ангийн мал аж ахуй дээр 30 хоног ажилласан бөгөөд ажил эхлэхээс өмнө ямар нэг сургалтад хамрагдаагүй

21 Зуд өвлийн улиралд тохиолддог байгалийн гамшиг бөгөөд бэлчээрлэх боломжгүйн улмаас мал олноор өлсөж үхдэг; энэ нь малчдын амьжиргааны эх үүсвэрийг доройтуулдаг.

байна. Хоёр цэргийн алба хаагч үерийн үеэр хүнсний ногоо хураах ажил хийсэн ба нэг цэргийн алба хаагч нь ажил эхлэхийн өмнө сургалтад хамрагджээ.

Халагдсан цэргийн судалгаанд үертэй холбоотой хоёр онцгой байдал, COVID-19-тэй холбоотой нэг онцгой байдал дурдагдсан. Нэг халагдсан цэрэг COVID-19 халдварын үеэр 2020 оны 8-р сарын 15-ны өдрөөс эхлэн 30 хоног ажилласан. Тэрээр ачаа зөөх үүрэгтэй байсан ба эхлэхийн өмнө ямар нэг сургалтад хамрагдаагүй. Өөр нэг халагдсан цэрэг ямар нэг сургалтгүйгээр үерийн үеэр хоёр өдөр ажилласан ба далан барих, үерт автсан байшингуудын шавар зөөх ажил хийжээ. Гурав дах тохиолдол нь үертэй холбоотой байна. Үерийн үеэр халагдсан цэргүүд ямар нэг сургалтгүйгээр гурав хоног Сэлбэ голын лаг цэвэрлэх ажил хийжээ.

4.8. Офицер, ахлагчдын хөдөлмөрийн нөхцөл

Судалгааны хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб болон Барилга инженерийн цэргийн удирдах газрын мэргэжилтнүүд болон офицер, ахлагчид нийлээд 25 мэргэжилтэн, алба хаагчидтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Эдгээр алба хаагчид болон мэргэжилтнүүдээс цэргийн албанаас чөлөөлөгдөх боломж ба зохицуулалт, хөдөлмөрийн нөхцөл болон гомдол гаргах үйл ажиллагаатай холбоотой чиглэлээр ярилцлага хийлээ.

4.8.1. Цэргийн албанаас чөлөөлөгдөх

Ярилцлага хийсэн офицер, ахлагчид болон мэргэжилтнүүд бүгд цэргийн албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх бүрэн боломжтой гэж хариулсан. Төрийн албаны цалин бага байсны улмаас сүүлийн жилүүдэд офицер, ахлагчид олноороо цэргийн албанаас чөлөөлөгдсөн байна. Ярилцлага өгсөн алба хаагчид бүгд өөрсдийн хамтран ажиллагсдыг саналаараа цэргийн албанаас гарсан тухайг ярьж байв. Цэргийн анги бүрт хуулийн офицер байдаг болсон нь албанаас чөлөөлөгдөх хууль, эрх зүйн мэдлэг мэдээлэлд эерэг нөлөөлсөн гэж үзэж байна. Чөлөөлөх өргөдлөө өгснөөс хойш 30 хоногийн дотор удирдлага нь өргөдлийн хариуг өгөх ёстой бөгөөд хэрхэн шийдвэрлэхээс үл хамааран өргөдлөө өгснөөс хойш 30 хоногийн дараа ажлын байраа орхиж явах боломжтой.

2014 оноос хойш цэргийн анги, нэгтгэл бүр хуулийн офицерын орон тоотой болжээ. Нэлээд олон офицер, ахлагчид хуулийн офицерын орон тоотой болсон нь маш чухал болохыг ярилцлагын үеэр онцолж байв. Үүний ачаар тэд өөрсдийн эрхээ мэддэг болж хууль зүйн зөвлөгөө авах боломжтой болсноор нөхцөл байдалд нь дорвитой өөрчлөлт орсон байна.

“2008 онд цэргийн албаны цалин өрхийн амьжиргаанд хангалтгүй байсан учраас миний бие албанаас чөлөөлөгдөхийг хүссэн. Миний бие хэд хэдэн удаа чөлөөлөгдөх хүсэлтээ өгөөд амжилтгүй болсон юм. Өргөдлүүдийг дарга маань ураад л өрөөнөөсөө гаргадаг байлаа. Тиймээс би цэргийн албанаас тухайн үедээ чөлөөлөгдөж чадаагүй. Тухайн үед би өргөдлөө өгөөд 30 хоногийн дараа ажлын байраа орхиод явж болно гэдгийг мэддэггүй байлаа. 2014 оноос хойш цэргийн анги, нэгтгэл бүрд хуулийн офицер байдаг болсноор мэргэжлийн алба хаагчид өөрийн хүсэлтээ чөлөөлөгдөх эрхтэй гэдгээ мэддэг болсон. Энэ хуулийн офицертой болсон явдал бидний хувьд их хэрэгтэй байгаа юм.”

“Сүүлийн үед хүмүүсийн хандлага их өөр болсон. Хүний эрхийн мэдлэг нь сайжирсан. Цэргийн алба ч орчин үеийн цаг үеэ дагаад өөрчлөгдөж байгаа гэж би хардаг. Миний ажиглаж байгаагаар хуучин цаг үед байсан шиг дэглэлт, дээрэлхэл гэдэг зүйл эрс багассан.”

“Би цэргийн албанд явахдаа дэглэлт гэдэг зүйлээс нь их айж байсан. Гэтэл бодит байдал төсөөлж байснаас минь өөр байсан. Миний алба хаасан цэргийн ангид ямар нэг дэглэлт, хүчирхийлэл гэж зүйл байгаагүй.”

Цэргийн албанд таваас бага жил ажилласан офицер, ахлагчдын хувьд нэг нөхцөл байдаг. Офицер, ахлагчид их сургуульдаа үнэ төлбөргүй сурдаг учраас төгсөөд албанд таван жил ажиллах ёстой гэсэн гэрээ байгуулдаг. Хэрэв энэ таван жилээ гүйцээлгүй цэргийн албанаас чөлөөлөгдөхөөр бол сургалтын төлбөрийн зарим хэсгийг болон албанаас үнэгүй авсан зүйлсийнхээ (дүрэмт хувцас, гутал болон бусад зүйлс) тодорхой хувийг ажилласан жилээсээ хамааран төлөх шаардлагатай болдог. Энэ нь нэг талаас харахад цэргийн албанаас чөлөөлөгдөхөд санхүүгийн хувьд хязгаарлалт болж байгаа мэт боловч офицер, ахлагчид өөрсдөө ингэж үздэггүй байна. Тэдний бодлоор энэ нь зүй ёсны зохицуулалт бөгөөд байхгүй тохиолдолд сургалтын төлбөр болон бусад хувцас хэрэглэлийг дааж байгаа цэргийн алба алдагдалтай ажиллахад хүрнэ гэж тайлбарлаж байв.

4.8.2. Хөдөлмөрийн нөхцөл

Ярилцлага өгсөн офицер, ахлагчид бүгд цалин бага учраас цэргийн албанд ажиллахад их хүндрэлтэй байдаг гэж байв. Үүнээс улбаалан офицер, ахлагчид нэлээд олноороо цэргийн албанаас чөлөөлөгдсөн байна. Харин саяхнаас цалин бага зэрэг нэмэгдэж, нийгмийн зарим асуудлыг шийдэх зохицуулалтууд хийгдсэнээр ажиллах хүчин харьцангуй тогтвортой болжээ. Тухайлбал, офицер, ахлагчид эрт тэтгэвэрт гардагтай холбоотойгоор тэтгэвэрт гарсны дараах ажил, мэргэжилд бэлтгэх сургалтад цалинтай хамруулдаг болсон байна.

Цалин болон бусад нийгмийн хангамж цэргийн албанд арваас доош жил ажилласан алба хаагчдын хувьд тийм ч ашигтай биш байдаг. Тэдний хувьд бага цалингаараа өрхийн амьжиргаагаа залгуулах шаардлагатай болдог. Харин арваас дээш жил цэргийн албанд ажилласан бол өндөр тэтгэвэр тогтоолгоод

эрт тэтгэвэртээ гарах боломж бүрддэг байна. Үүнийг ярилцлагын үеэр ч алба хаагчид хэлж байв. Таваас бага жил цэргийн албанд ажилласан алба хаагчдын хувьд чөлөөлөгдөх үед төлөх ёстой өр төлбөр нь бас нэг хязгаарлалт болдог.

“Цэргийн ангид шаардлагатай бичиг хэрэгсэл, байр, өрөөний тохижилт, засвартай холбоотой зардлыг бид хувийн мөнгөөрөө санхүүжүүлэх шаардлагатай болдог. Миний өмнө ажиллаж байсан цэргийн ангид бичиг хэргийн жилийн зардалд төсвөөс 250,000 төгрөг өгдөг байсан. Та төсөөлж байна уу? Ажлын компьютер хэтэрхий хуучирсан байдаг байсан. Хэвлэх машингүй цэргийн ангиуд ч байдаг юм. Гэтэл удирдлагын зүгээс биднээс гоё, боловсронгуй дизайн, өнгөтэй зүйлс бэлтгэж өгөхийг шаарддаг. Маш муу хангамжтай цэргийн ангиудаас их өндөр шаардлагатай зүйлс хийхийг хүсдэг.”

“Бид цэргийн бус хийсэн ажлуудаас олсон орлогынхоо талыг нь ангийн дансанд оруулдаг. Ингэснээр ус шүүгч, биеийн тамирын заал засах гэх мэт дундын зүйлсээ шийдвэрлэх боломжтой болдог юм.”

“Томилолтын зардлын санхүүжилтийг асуудлыг шийдэж өгөөсэй гэж их хүсдэг. Заримдаа томилолтын зардлыг хувиасаа санхүүжүүлдэг. Энэ талаараа санхүүгийн ажилтандаа гомдол гаргахаар төсөв байхгүй гэж хэлдэг. Офицер, ахлагчдын дунд томилолтын зардалтай холбоотой гомдол их түгээмэл байдаг.”

Офицер, ахлагчид үндсэн үүрэгт ажлаасаа гадна төмөр зам барих, ургац, ногоо хураалтад явах зэрэг цэргийн бус ажил нэлээд их хийдэг. Эдгээр цэргийн бус ажлын хөлсний 50 хувийг өөрсдөө авдаг бөгөөд 50 хувь нь цэргийн ангийн орлого болдог жишиг тогтжээ. Бичиг хэргийн зардал болон өрөө, байрны урсгал засварт төсвөөс өгдөг санхүүжилт хангалтгүй байдаг учраас цэргийн бус ажлаас олсон орлогоор дутуу хэсгийг санхүүжүүлдэг ажээ. Ярилцлага өгсөн офицер, ахлагчдын зарим нь энэ байдал нь тэдний дундын нийтлэг асуудлыг шийдэхэд зайлшгүй чухал гэсэн бодолтой байхад зарим нь үүнд нэлээд шүүмжлэлтэй ханддаг байна. Шүүмжлэлтэй хандаж байгаа алба хаагчдын хувьд тэд үндсэн цэргийн үүрэгт ажилдаа анхаарлаа хандуулж байх ёстой гэж үздэг байна. Харин төмөр замын ажил онцлогтой байсан тухай тэд ярьж байсан. Учир нь төмөр зам дээр ажилласан алба хаагчид нэлээд өндөр цалин авсан бөгөөд цалин нь 100 хувь тэдний дансанд орсон байна.

4.8.3. Гомдол гаргах журам

Цэргийн албаны гомдол гаргах үйл ажиллагаанд тодорхой дэвшлүүд гарчээ. Тухайлбал, гомдол, санал хүсэлт хүлээн авах утасны шугам ажиллуулдаг болсон бөгөөд цэргийн анги бүрт хуулийн офицертой болсон. Зарим цэргийн ангиудад нэргүй гомдол, санал авах хайрцаг байршуулдаг болжээ. Хугацаат цэргийн алба хаагчид болонофицер, ахлагчид аливаа гомдлоо албан ёсоор өөрийн шууд удирдлагаараа заавал дамжуулж гаргах ёстой.

Нөгөө талаас хугацаат цэргийн алба хаагчид болон офицер, ахлагчид гомдлоо ил тод илэрхийлэх боломжгүй байдаг нь ажиглагдсан. Ихэнх нь бид тушаалаар ажилладаг улс учраас дээд удирдлагаас өгсөн аливаа шийдвэрийг эсэргүүцэх боломжгүй гэж байв. Нэлээд олон офицер, ахлагчид цэргийн алба бол жирийн нэг алба биш, цэрэг бол тангараг өргөсөн бөгөөд эрхээ хязгаарлуулсан хүн гэж ярих бөгөөд ийм учраас тэр бүр гомдол гаргаад байх нь зохимжгүй үздэг байна.

"Бид цэргийн албаны цэргүүд учраас үргэлж гомдол гаргаад байж болохгүй. Үер боллоо гээд шөнө дунд дуудах үед гомдоллоод суугаад байх боломжгүй шүү дээ."

"Одоогийн армийн гомдол гаргах үйл ажиллагаатай би санал нийлдэггүй. Цэргүүд шууд өөрийн удирдлагаараа дамжуулж гомдлоо гаргах ёстой. Нэг гомдол гаргахад тэрний тухай хоёр, гурван өдрийн дараа бүгд мэдчихсэн байдаг. Гэхдээ одоогийн залуу үе өөр болсон болохоор хуучны энэ хандлага өөрчлөгдөх байх гэж найдаж байна."

"Гомдол гаргаад нэмэргүй байсан. Гомдлын мөрөөр ямар нэг арга хэмжээ авах эсвэл хариу өгнө гэж байхгүй юм билээ. Би алба хааж байхдаа бусад цэргүүдтэй нийлээд ажлын нөхцөлийн талаар гомдол гаргаж байсан. Бид их хүнд нөхцөлд, олон цагаар ажиллаж байгаа тухайд гомдол гаргасан. Бид бүгд нийлээд захиа бичсэн. Үүний үр дүнд юу ч болоогүй өнгөрсөн."

Гомдол гаргахтай холбоотой нэг дэвшил бий болсон нь хугацаат цэргийн алба хаагчид долоо хоногт нэг удаа гэр бүлтэйгээ ярих боломжтой болсон явдал юм. Ингэснээр цэргийн алба хаагчид асуудлаа өөрсдийн эцэг, эх болон гэр бүлийнхэнтэйгээ ярилцах боломжтой болсон байна. Өөрөөр хэлбэл, тэд гомдлоо гэр бүлээрээ дамжуулаад гаргах боломжтой болсон гэсэн үг. Офицер, ахлагчдын ярилцлагаас үзэхэд цэргийн ар гэр, эцэг эхчүүд армийн үйл ажиллагааны хамгийн чухал хөндлөнгийн хяналт болдог байна.

► 5. Дүгнэлт

Монгол Улсын өнөөгийн хууль тогтоомж болон бодлого нь заавал хаах цэргийн алба хааж буй иргэдээр цэргийн бус ажил, үйлчилгээ хийлгүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Ялангуяа Зэвсэгт хүчний тухай хуульд ((3.1.17, 6.2.11, 6.3, 11.1.15, 13.1.13, 181.2.6, ба 181.3.8 заалтууд)) хугацаат цэргийн алба хаагч цэргийн бус ажил, үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь ОУХБ-ын 29 болон 105 дугаар конвенц, Монгол Улсын Хөдөлмөрийн хуультай зөрчилдөж байгаа юм. Монгол Улсад 29 болон 105 дугаар конвенцуудын талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах шаардлагатай байна. Улс төрчдийн дунд хүртэл конвенцуудын талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах нь чухал байна. Тухайлбал 2015 онд Монголын ардчилсан холбооны Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Барилга, хот байгуулалтын дэд сайд асан Г.Байгалмаа албадан хөдөлмөр гэдгийн ард ямар ч цалин гэх ойлголт байдаггүй, хугацаат цэргийн алба хаагчид цалинтай ажиллаж байгаа бол албадан хөдөлмөр биш юм гэж ярилцлага өгсөн байна.²²

Хугацаат цэргийн алба хаагчдаар хийлгэж буй цэргийн бус ажил, үйлчилгээ нь албадан хөдөлмөрийн шинжтэй байна хэмээн судалгааны үр дүнгээс дүгнэж болно. Судалгаанд хамрагдсан хугацаат цэргийн алба хаагчдын 30 гаруй хувь нь дор хаяж нэг цэргийн бус ажил хийсэн бөгөөд маш цөөн тохиолдолд онцгой байдлын улмаас цэргийн бус ажил, үйлчилгээ хийсэн байна. Барилга-инженерийн цэргийн ангиудаас бусад ангиудын хувьд хамгийн их хийж буй цэргийн бус ажил нь ургац, ногоо хураалтын ажил (38.6%) байна. Барилга-инженерийн цэргийн ангийн алба хаагчид ургац, ногоо хураалтын ажилд мөн оролцдог гэж 2.8 хувь нь хариулсан.

Гүнзгийрүүлсэн ярилцлага болон асуумж судалгаанаас барилга-инженерийн цэргийн ангийн алба хаагчид мэргэшил олгох сургалтад хамрагддаг бөгөөд эдгээр сургалтын хүрээнд цэргийн бус ажил мөн хийдэг байна. Мэргэшил олгох сургалтад хамрагдсан гэсэн цэргүүд бүгд сайн дураараа уг сургалтад хамрагдсан байна. Харин судалгаанд хамрагдсан 100 халагдсан цэргүүдээс ердөө гурав нь мэргэшил олгох сургалтад хамрагдсан байв. Судалгааны үеэр алба хааж байсан хугацаат цэргийн алба хаагчдын 41 хувь цэргийн бус ажил, үйлчилгээ эрхэлсэн байсан бол халагдсан цэргүүдийн 94 хувь нь цэргийн бус ажил, үйлчилгээ эрхэлсэн байв. Эндээс хугацаат цэргийн алба хаагчдаар цэргийн бус ажил хийлгэх нь буурсан хэдий ч ийм практик байсаар байгаа гэдгийг харж болно.

²² <https://www.assa.mn/a/34130>.

Хугацаат цэргийн алба хаагчид цэргийн бус ажлыг цалингүй хийх нь нэлээд их бөгөөд асуумж судалгаанд мэдүүлснээр ийм төрлийн ажлын хөлс хамгийн бага, мэдэгдэхүйц хэлбэлзэлтэй байна. Мөн түүнчлэн цэргүүд олон цагаар ажилладаг нь сард 22 өдөр, өдрийн 8 цагаар ажиллах хуулийн хязгаараас хамаагүй илүү байгааг судалгаа харуулж байна.

Цэргийн ангийн удирдлагууд болон мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас ажиглахад хугацаат цэргийн алба хаагчид болон офицер, ахлагчдын хөдөлмөрийн аюулгүй байдалд онцгойлон анхаарал тавьдаг байна. ХАБЭМ хариуцсан алба хаагчдыг байнгын сургалтад хамруулдаг бөгөөд цэргийн анги, нэгтгэлүүд болон байгууллагуудад тогтмол ХАБЭМ-ийн шалгалт хийдэг байна. Хугацаат цэргийн алба хаагчидтай хийсэн ярилцлагын үеэр цэргүүдэд ажил эхлэхийн өмнө ХАБЭМ-ийн зааварчилгааг өгдөг бөгөөд хамгаалах хувцас хэрэглэл болох маск, бээлий, каскаар хангадаг байна. Гэхдээ хөнгөн хэлбэрийн бэртэл авсан гэх тохиолдлууд яригдаж байв.

Офицер, ахлагчид цэргийн албанаас сайн дураараа чөлөөлөгдөх боломжтой бөгөөд энэ нь Хөдөлмөрийн хуулийн дагуу шийдвэрлэгддэг. Энэ асуудал дээр цэргийн албанд ахиц дэвшил гарсан байна. Учир нь цэргийн анги бүрд хуулийн офицер байх боломжтой болсноор офицер, ахлагчид албанаас чөлөөлөгдөх хууль, дүрэм журмыг мэддэг болсон бөгөөд чөлөөлөгдөхөд ямар нэг саад, бэрхшээл гардаггүй.

Офицер, ахлагчид үндсэн үүрэгт ажлаасаа гадна төмөр зам болон зам барих, ургац, ногоо хураах зэрэг цэргийн бус ажил, үйлчилгээ хийдэг. Цэргийн бус ажлаас авсан цалингийн 50 хувийг алба хаагч, 50 хувийг ангийн дансанд төвлөрүүлдэг. Гэхдээ офицер, ахлагчид нь сайн дураараа албанаас чөлөөлөгдөх боломжтой учраас тэдний хийж буй цэргийн бус ажил нь албадан хөдөлмөр гэж тооцогдохгүй болно. Офицер, ахлагчдын хувьд цалин бага байдаг нь, ялангуяа ажил, мэргэжлийн гараагаа дөнгөж эхлүүлж буй алба хаагчдын хувьд хүндрэлтэй байдаг байна. Алба хаагчид болон мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагуудын үеэр цэргийн албанд 10-аас дээш жил ажилласан бол өндөр тэтгэвэр тогтоолгох, эрт тэтгэвэрт гарах боломжтой болдог байна. Гэвч сүүлийн жилүүдэд цалин багаас болж офицер, ахлагчид олноороо цэргийн албанаас чөлөөлөгдсөн байна.

► 6. Зөвлөмж

1. Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд зарим цэргийн анги нэгтгэлүүдийг байлдааны бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр барилга, аж ахуйн ажил зэрэг цэргийн бус шинж чанартай ажилд татан оролцуулж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, соёрхон баталсан олон улсын гэрээнд нийцэхгүй байгаа тул нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 208 дугаар зарлигийн дагуу цэргийн алба хаагчдын аж ахуйн ажил, бүтээн байгуулалтын ажлын зарим хэсэгтэй холбоотой зохицуулалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зүйл заалтыг зөрчсөн байна. Дээрх журмын 2.1.1, 2.1.2-ыг ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцод заасан шаардлагад нийцүүлэн нэн даруй өөрчлөхийг зөвлөж байна.
3. Өнөөдрийн байдлаар Батлан хамгаалахын сайд, Сангийн сайдын 2020 оны А/39/28 дугаар хамтарсан тушаал, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2022 оны А/466 дугаар тушаалаар бүтээн байгуулалт, аж ахуйн ажилд оролцсон зэвсэгт хүчинд цалин хөлс олгож байна. Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад үндэслэн дүгнэвэл эдгээр шийдвэр хүчин төгөлдөр бус байх магадлалтай гэж үзсэн. Иймд эдгээр шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн яам нэн даруй хянаж, холбогдох хуульд нийцүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан Цэргийн ерөнхий дүрмийн 16 дугаар хавсралтаар батлагдсан Өргөдөл, гомдол шийдвэрлэх журмын 7 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ангийн захирагчтай холбоотой асуудлаар гаргах гомдлыг дээд шатны албан тушаалтанд шууд гаргах боломжийг нээж өгөх нь зүйтэй.
5. ОУХБ-ын 29 болон 105 дугаар конвенцын хэрэглээг нэмэгдүүлж, хүртээмжтэй болгохын тулд Монгол орчуулгыг хууль, тогтоомжуудын нэгдсэн платформд байршуулах нь зүйтэй.

► Ашигласан материалын жагсаалт

ILO. 1979. *Report of the Committee of Experts on the Application of Conventions and Recommendations*. ILC.65/III(4B).

— 2007. *Report of the Committee of Experts on the Application of Conventions and Recommendations*. ILC.96/III(1B).

— 2021. *Report of the Committee of Experts on the Application of Conventions and Recommendations*. ILC.109/III. Direct request, adopted 2019. https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13100:0::NO:13100:P13100_COMMENT_ID,P13100_COUNTRY_ID:3997774,103142.

— 2023. *Report of the Committee of Experts on the Application of Conventions and Recommendations*. ILC.111/III. Direct request, adopted 2022. https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13100:0::NO:13100:P13100_COMMENT_ID,P13100_COUNTRY_ID:4325304,103142:NO.

— and MN-NHRC (National Human Rights Commission of Mongolia). 2016. *Compulsory Military Service and Conscripts Labour in Mongolia: Review of Policy and Practice*. Ulaanbaatar.

Монгол Улсын холбогдох хуулиуд.

— Монгол Улсын Батлан хамгаалах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/12122>.

— Цэргийн албан тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124>.

— Зэвсэгт хүчний тухай, <https://legalinfo.mn/mn/detail/12123>.

— Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12125>.

— Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, <https://legalinfo.mn/mn/detail/576>.

— Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай, <https://legalinfo.mn/mn/detail/578>.

— Хөдөлмөрийн тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>.

— Төрийн албаны тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13025>.

— Төрийн болон албаны нууцын тухай, <https://legalinfo.mn/mn/detail/12408>.

— Байгууллагын нууцын тухай, <https://legalinfo.mn/mn/detail/102>.

Зэвсэгт хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, Хууль зүйн судалгааны төв, Улаанбаатарт хот, 2021 он.

ҮСХ. Хүн ам, өрхийн хүснэгт. www.1212.mn.

► Хавсралт: Асуумжийн хуудас болон ярилцлагын асуултууд

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АСУУЛТ

ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

Та Монгол Улс дахь хугацаат цэргийн алба хаагчид болон цэргийн алба хаагчдын судалгаанд оролцохоор сонгогдсон. Энэхүү судалгаа нь хугацаат цэргийн алба хаагчид болон цэргийн алба хаагчдын хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл, Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын конвенцын хэрэгжилтийн талаар судлах зорилготой юм. Энэхүү судалгааг Үндэсний судалгаа, зөвлөгөө өгөх төвөөс (NRCC) ОУХБ-ын дэмжлэгтэйгээр хийж байна. Судалгааны багийн гишүүд ОУХБ-ын холбогдох сургалтад хамрагдсан болно.

Ярилцлага зургаан минут орчим үргэлжилнэ. Цэргийн албаныхаа хүрээнд хийж байсан ажлуудын талаар асуулт асууя. Таны оролцоо бүрэн нууц байх болно.

Энэхүү судалгаагаар олж авсан бүх мэдээлэл нь нууц бөгөөд зөвхөн судалгааны зорилгоор ашиглагдана. Мэдээллийг зөвхөн нэгтгэсэн дүгнэлт гаргахад ашиглах бөгөөд шууд цахим маягтаар дамжуулан ярилцлага авагч болон ажиглагчийг байлцуулан авна.

Та энэ судалгаанд оролцохыг зөвшөөрч байна уу? () Тийм () Үгүй

Зөвшөөрлийн маягтанд гарын үсэг зурснаар та ямар судалгаанд оролцож байгаагаа ойлгож, улмаар оролцохыг зөвшөөрч байна гэсэн үг юм.

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг хоёр хувь үйлдсэн. Та оролцох хүсэлтэйгээ баталгаажуулсны дараа нэг хувь нь хариуцах судлаачид, нөгөө нь танд үлдэх болно.

Цэргийн анги:	
Судалгаа бөглөсөн огноо:	

1. Оролцогчийн тухай мэдээлэл

- 1.1. Таны нас:
- 1.2. Таны үндсэн харьяа
 - a. Улаанбаатар
 - b. Аймгууд – жагсаалтаас сонгоно уу
- 1.3. Таны боловсролын түвшин:
 - a. Боловсролгүй
 - b. Бага
 - c. Дунд
 - d. Бүрэн дунд
 - e. Тусгай дунд
 - f. Дээд, түүнээс дээш
- 1.4. Та ямар үндэс, угсаатай вэ?
 - a. Халх
 - b. Казак
 - c. Тува
 - d. Бусад.....
- 1.5. Та ямар шашин шүтдэг вэ?
 - a. Шашин шүтдэггүй
 - b. Будда
 - c. Бөө
 - d. Христ
 - e. Ислам
 - f. Бусад.....
- 1.6. Та цэрэгт хэзээ татагдсан бэ?
 - a. 2022 онд
 - b. 2023 онд
- 1.7. Энэ ангид аяж хуваарилагдсан бэ?
 - a. Өөрийн хүсэлтээр
 - b. Томилогдсон

2. Хугацаат цэргийн алба хаагчдын ажил

- 2.1. Та цэрэгт байх хугацаандаа ямар төрлийн ажлууд хийсэн бэ? (Олон хариулт сонгож болно)
Заавар: Сонголтуудыг уншиж байхдаа хариултыг шалгана уу
 - a. Байлдааны гэх мэт цэргийн ажиллагаанд оролцох буюу дэмжих → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - b. Байлдааны гэх мэт цэргийн ажиллагааны сургалт → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - c. Цэргийн алба хаагчид болон бусад хугацаат цэргийн алба хаагчдын дотуур байр, гал тогоо, бие засах газар цэвэрлэх, хоол хийх зэрэг цэргийн ангийн хэвийн үйл ажиллагааг хангах → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - d. Цэргийн даалгаварт армийн тээврийн хэрэгслийн жолооч хийх → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - e. Цэргийн алба хаагчдын хүүхдийг сургууль руу нь хүргэж өгөх, тэднийг ар

- гэрийнхээ ажлаар дэлгүүр орох гэх мэт цэргийн үүрэг даалгавраас өөр ажилд
жолоочоор ажиллах
- f. Армийн тээврийн хэрэгслийн засвар → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - g. Иргэний тээврийн хэрэгслийн засвар
 - h. Эмнэлэг, сургалтын байгууламж зэрэг армийн барилга байгууламж барих, засвар
үйлчилгээ хийх → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - i. Нийтийн барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийх (жишээлбэл сургууль,
эрүүл мэндийн төв гэх мэт)
 - j. Хувийн барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийх (жишээлбэл, орон
сууцны барилга)
 - k. Төмөр зам, авто зам, гүүр, далан, шугам хоолой барих, засварлах
 - l. Хувийн компани болон хувь хүмүүсийн жолоочоор ажилладаг
 - m. Авто зам, гол мөрний цэвэрлэгээ
 - n. Уул уурхай
 - o. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл
 - p. Газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалах, ургац хураах
 - q. Мал аж ахуй
 - r. Мод бэлтгэх, мод боловсруулах
 - s. Хэвлэлийн цех
 - t. Гар урлал
 - u. Оёдол, цех
 - v. Нэхмэл, ноосон эдлэлийн үйлдвэрлэл
 - w. Цэргийн удирдах ажилтан эсвэл түүний гэр бүлд хоол хийх, гэрийн ажил хийх гэх
мэт үйлчилгээ үзүүлэх
 - x. Бусад.....

3. Цэргийн бус ажлын онцлог

a, b, c, d, f, h-аас бусад аль ч хувилбарын хувьд сонгосон ажлын тоогоор давтан асууна

2.1-д сонгосон ажлуудыг нэрлэж асууна уу.

- 3.1. Та энэ ажлаа хэзээнээс хийж эхэлсэн бэ?
Огноо.....
- 3.2. Таны хийх үүрэг, даалгавар юу байсан бэ?
.....(бичих)
- 3.3. Та яаж энэ ажилд томилогдсон бэ ?
 - a. Цэргийн ангийн удирдлага томилсон → **3.5 асуулт**
 - b. Би өөрөө томилогдох хүсэлт гаргасан
 - c. Мэдэхгүй → **3.5 асуулт**
- 3.4. Та яагаад энэ ажилд томилогдох хүсэлт гаргасан бэ?
 - a. Орлого олохын тулд
 - b. Ур чадвартай болохын тулд
 - c. Бусад.....
- 3.5. Та энэ ажлаа хийсний төлөө мөнгөн эсвэл мөнгөн бус хэлбэрээр хөлс авсан эсвэл авч
байгаа юу?
 - a. Тийм
 - b. Үгүй → **3.10 асуулт**

- c. Цэргээс халагдсаны дараа цалин болгож өгнө гэсэн
- 3.6. Та ямар хэлбэрээр цалин хөлсөө авдаг эсвэл авсан бэ?
 - a. Бэлэн мөнгө
 - b. Дансаар
 - c. Купон → **3.9**
 - d. Мөнгөн бус хэлбэрээр → **3.9**
 - e. Чөлөөгөөр шагнуулдаг → **3.10**
 - f. Бусад.....
- 3.7. Та цалингаа ямар давтамжтай авдаг вэ?
 - a. Өдрийн давтамжтай
 - b. Долоо хоногийн давтамжтай → **3.8.2**
 - c. Сарын давтамжтай → **3.8.3**
 - d. Цэргээс халагдахдаа бөөнд нь авна → **3.8.4**
- 3.8.1. Та өдрийн хэдэн төгрөгийн цалин авч байгаа эсвэл авсан бэ?

.....**мян.төгрөг**
- 3.8.2. Та долоо хоногийн хэдэн төгрөгийн цалин авч байгаа эсвэл авсан бэ?

.....**мян.төгрөг**
- 3.8.3. Та сарын хэдэн төгрөгийн цалин авч байгаа эсвэл авсан бэ?

.....**мян.төгрөг**
- 3.8.4. Та халагдаад хэдэн төгрөгийн цалин авахаар байгаа вэ?

.....**мян.төгрөг**
- 3.9. Таны мөнгөн бус хэлбэрээр авсан хөлс эсвэл купон хэдэн төгрөгтэй тэнцэх вэ?

.....**мян.төгрөг**
- 3.10. Таны хийдэг эсвэл хийсэн ажил хаана байрладаг вэ?
 - a. Цэргийн ангид
 - b. Өөр цэргийн ангид
 - c. Цэргийн ангийн харьяа объект, талбайд
 - d. Төрийн өмчийн харьяа объект, талбайд
 - e. Хувь хүний эзэмшлийн харьяа объект, талбайд
- 3.11. Та хийх ажлын үүрэг, цалин хөлс болон ажиллах цагийн талаар гэрээ байгуулдаг уу?
 - a. Аман гэрээ байгуулдаг
 - b. Бичгээр гэрээ байгуулдаг
 - c. Үгүй → **3.13**
- 3.12. Гэрээнд тохирсон нөхцлүүд бүгд хэрэгждэг үү? (Олон сонголттой)
 - a. Тийм, гэрээнд заасан ажил үүрэг, ажлын цаг, цалин бүгд бодитоор хэрэгждэг
 - b. Үгүй, ажил үүрэг өөрчлөгддөг
 - c. Үгүй, цалин хөлс өөрчлөгддөг
 - d. Үгүй, ажлын цаг өөрчлөгддөг
- 3.13. Та энэ ажлыг хэр их хийдэг вэ?
 - a. Тогтмол
 - b. Хааяа
 - c. Онцгой байдал үүссэн үед хийдэг → **Бүлэг 4**
- 3.14. Энэ ажлыг сард хэдэн өдөр хийдэг вэ?

Өдрийн тоо.....
- 3.15. Энэ ажлыг өдөрт хэдэн цаг хийдэг вэ?

Өдрийн тоо..... → **Бүлэг 5**

4. Онцгой байдал үүссэний улмаас хийсэн ажил

- 4.1. Ямар онцгой байдал үүссэн бэ?
- a. Эуд
 - b. Гал, түймэр
 - c. Үер
 - d. Газар хөдлөлт
 - e. Нийтийг хамарсан цар тахал
 - f. Амьтдын нүүдэл
 - g. Бусад.....

Ажилласан гэж сонгосон бүх онцгой байдал бүрээр доорх асуултуудыг асууна.

- 4.2. Та онцгой байдалд хэзээ ажилласан бэ?
Огноо.....
- 4.3. Та..... онцгой байдалд хэдэн өдөр ажилласан бэ?
Огноо.....
- 4.4. нөхцөлд ажиллахын өмнө таныг ямар нэг сургалтад хамруулсан уу?
- a. Тийм
 - b. Үгүй

5. Сургалт

- 5.1. Энэ ажлыг ямар нэг чадамж олгох сургалтын хүрээнд хийсэн үү?
- a. Тийм
 - b. Үгүй → **дуусгах**
- 5.2. Та энэ сургалтаар ямар ур чадвар эсвэл мэргэшил эзэмшсэн бэ ?
(бичих)
- 5.3. Та энэ сургалтад өөрийн хүсэлтээр сурсан уу?
- a. Тийм → **5.6**
 - b. Үгүй
- 5.4. Та ангийн удирдлагадаа энэ сургалтад суухаас татгалзаж буйгаа илэрхийлсэн үү?
- a. Тийм
 - b. Үгүй
- 5.5. Та сургалтад суухыг хүсээгүй боловч суусан шалтгаанаа сонгоно уу? (Олон сонголттой)
- a. Ангийн удирдлага хүссэн бөгөөд би тушаалыг зөрчиж чадахгүй
 - b. Би биеийн тамирын дасгал хийх шийтгэл хүлээхээс айдаг
 - c. Би чөлөөт цагаа хасуулах шийтгэл хүлээхээс айдаг
 - d. Би нэмэлт ажил хийх шийтгэлээс айдаг
 - e. Би хоригдох шийтгэл хүлээхээс айдаг
 - f. Би бусад цэргийн өмнө доромжлуулахыг хүсдэггүй
 - g. Би хийдэг ажил дээрээ тушаал буурахаас айдаг
 - h. Би бие махбодийн, бэлгийн гэх мэт хүчирхийллээс айдаг
 - i. Бусад.....
- 5.6. Та энэ сургалтаасаа гэрчилгээ авсан (авах) уу?
- a. Тийм
 - b. Үгүй

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА.

ХАЛАГДСАН ЦЭРГҮҮДЭЭС АВАХ АСУУЛТ

ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

Та Монгол Улс дахь хугацаат цэргийн алба хаагчид болон цэргийн алба хаагчдын судалгаанд оролцохоор сонгогдсон. Энэхүү судалгаа нь хугацаат цэргийн алба хаагчид болон цэргийн алба хаагчдын хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл, Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын конвенцын хэрэгжилтийн талаар судлах зорилготой юм. Энэхүү судалгааг Үндэсний судалгаа, зөвлөгөө өгөх төвөөс (NRCC) ОУХБ-ын дэмжлэгтэйгээр хийж байна. Судалгааны багийн гишүүд ОУХБ-ын холбогдох сургалтад хамрагдсан болно.

Ярилцлага зургаан минут орчим үргэлжилнэ. Цэргийн албаныхаа хүрээнд хийж байсан ажлуудын талаар асуулт асууя. Таны оролцоо бүрэн нууц байх болно.

Энэхүү судалгаагаар олж авсан бүх мэдээлэл нь нууц бөгөөд зөвхөн судалгааны зорилгоор ашиглагдана. Мэдээллийг зөвхөн нэгтгэсэн дүгнэлт гаргахад ашиглах бөгөөд шууд цахим маягтаар дамжуулан ярилцлага авагч болон ажиглагчийг байлцуулан авна.

Та энэ судалгаанд оролцохыг зөвшөөрч байна уу? () Тийм () Үгүй

Зөвшөөрлийн маягтанд гарын үсэг зурснаар та ямар судалгаанд оролцож байгаагаа ойлгож, улмаар оролцохыг зөвшөөрч байна гэсэн үг юм.

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг хоёр хувь үйлдсэн. Та оролцох хүсэлтэйгээ баталгаажуулсны дараа нэг хувь нь хариуцах судлаачид, нөгөө нь танд үлдэх болно.

Судалгаа бөглөсөн огноо:	
--------------------------	--

1. Оролцогчийн тухай мэдээлэл

- 1.8. Таны нас:
- 1.9. Таны боловсролын түвшин:
 - g. Боловсролгүй
 - h. Бага
 - i. Дунд
 - j. Бүрэн дунд
 - k. Тусгай дунд
 - l. Дээд, түүнээс дээш
- 1.10. Та ямар үндэс, угсаатай вэ?
 - e. Халх
 - f. Казак
 - g. Тува
 - h. Бусад.....

- 1.11. Та ямар шашин шүтдэг вэ?
- g. Шашин шүтдэггүй
 - h. Будда
 - i. Бөө
 - j. Христ
 - k. Ислам
 - l. Бусад.....
- 1.12. Та цэрэгт хэзээ татагдсан бэ?
- Он.....
- 1.13. Та хэзээ цэргээс халагдсан бэ?
- Он.....
- 1.14. Энэ ангидаа яаж хуваарилагдсан бэ?
- c. Өөрийн хүсэлтээр
 - d. Томилогдсон
- 1.15. Таны цэрэгт татагдах үеийн үндсэн харьяа
- a. Улаанбаатар
 - b. Аймгууд – жагсаалтаас сонгоно уу

2. Хугацаат цэргийн алба хаагчдын ажил

- 2.1. Та цэрэгт байх хугацаандаа ямар төрлийн ажлууд хийсэн бэ? (Олон хариулт сонгож болно)
- Заавар: Сонголтуудыг уншиж байхдаа хариултыг шалгана уу*
- a. Байлдааны гэх мэт цэргийн ажиллагаанд оролцох буюу дэмжих → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - b. Байлдааны гэх мэт цэргийн ажиллагааны сургалт → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - c. Цэргийн алба хаагчид болон бусад хугацаат цэргийн алба хаагчдын дотуур байр, гал тогоо, бие засах газар цэвэрлэх, хоол хийх зэрэг цэргийн ангийн хэвийн үйл ажиллагааг хангах → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - d. Цэргийн даалгаварт армийн тээврийн хэрэгслийн жолооч хийх → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - e. Цэргийн алба хаагчдын хүүхдийг сургууль руу нь хүргэж өгөх, тэднийг ар гэрийнхээ ажлаар дэлгүүр орох гэх мэт цэргийн үүрэг даалгавраас өөр ажилд жолоочоор ажиллах
 - f. Армийн тээврийн хэрэгслийн засвар → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - g. Иргэний тээврийн хэрэгслийн засвар
 - h. Эмнэлэг, сургалтын байгууламж зэрэг армийн барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийх → **зөвхөн энэ хариулт бол дуусгах**
 - i. Нийтийн барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийх (жишээлбэл сургууль, эрүүл мэндийн төв гэх мэт)
 - j. Хувийн барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийх (жишээлбэл, орон сууцны барилга)
 - k. Төмөр зам, авто зам, гүүр, далан, шугам хоолой барих, засварлах
 - l. Хувийн компани болон хувь хүмүүсийн жолоочоор ажилладаг
 - m. Авто зам, гол мөрний цэвэрлэгээ

- п. Уул уурхай
- о. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл
- р. Газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалах, ургац хураах
- қ. Мал аж ахуй
- г. Мод бэлтгэх, мод боловсруулах
- с. Хэвлэлийн цех
- т. Гар урлал
- и. Оёдол, цех
- v. Нэхмэл, ноосон эдлэлийн үйлдвэрлэл
- w. Цэргийн удирдах ажилтан эсвэл түүний гэр бүлд хоол хийх, гэрийн ажил хийх гэх мэт үйлчилгээ үзүүлэх
- х. Бусад.....

3. Цэргийн бус ажлын онцлог

a, b, c, d, f, h-аас бусад аль ч хувилбарын хувьд сонгосон ажлын тоогоор давтан асууна

2.1-д сонгосон ажлуудыг нэрлэж асууна уу.

- 3.1. Та энэ ажлаа хэзээнээс хийж эхэлсэн бэ?
Огноо.....
- 3.2. Таны хийх үүрэг, даалгавар юу байсан бэ?
.....(бичих)
- 3.3. Та яаж энэ ажилд томилогдсон бэ ?
 - a. Цэргийн ангийн удирдлага томилсон → **3.5 асуулт**
 - b. Би өөрөө томилогдох хүсэлт гаргасан
 - c. Мэдэхгүй → **3.5 асуулт**
- 3.4. Та яагаад энэ ажилд томилогдох хүсэлт гаргасан бэ?
 - a. Орлого олохын тулд
 - b. Ур чадвартай болохын тулд
 - c. Бусад.....
- 3.5. Та энэ ажлаа хийсний төлөө мөнгөн эсвэл мөнгөн бус хэлбэрээр хөлс авсан эсвэл авч байсан уу?
 - a. Тийм
 - b. Үгүй → **3.10 асуулт**
 - c. Цэргээс халагдсаны дараа цалин болгож өгнө гэсэн
- 3.6. Та ямар хэлбэрээр цалин хөлсөө авсан бэ?
 - a. Бэлэн мөнгө
 - b. Дансаар
 - c. Купон → **3.9**
 - d. Мөнгөн бус хэлбэрээр → **3.9**
 - e. Чөлөөгөөр шагнуулдаг → **3.10**
 - f. Бусад.....
- 3.7. Та цалингаа ямар давтамжтай авдаг байсан бэ?
 - a. Өдрийн давтамжтай
 - b. Долоо хоногийн давтамжтай → **3.8.2**

- с. Сарын давтамжтай → **3.8.3**
- д. Цэргээс халагдахдаа бөөнд нь авсан → **3.8.4**
- 3.8.1. Та өдрийн хэдэн төгрөгийн цалин авсан бэ?
.....**мян.төгрөг**
- 3.8.2. Та долоо хоногийн хэдэн төгрөгийн цалин авсан бэ?
.....**мян.төгрөг**
- 3.8.3. Та сарын хэдэн төгрөгийн цалин авсан бэ?
.....**мян.төгрөг**
- 3.8.4. Та халагдаад хэдэн төгрөгийн цалин авсан бэ?
.....**мян.төгрөг**
- 3.9. Таны мөнгөн бус хэлбэрээр авсан хөлс эсвэл купон хэдэн төгрөгтэй тэнцэх вэ?
.....**мян.төгрөг**
- 3.10. Таны хийдэг эсвэл хийсэн ажил хаана байрладаг вэ?
 - f. Цэргийн ангид
 - g. Өөр цэргийн ангид
 - h. Цэргийн ангийн харьяа объект, талбайд
 - i. Төрийн өмчийн харьяа объект, талбайд
 - j. Хувь хүний эзэмшлийн харьяа объект, талбайд
- 3.11. Та хийх ажлын үүрэг, цалин хөлс болон ажиллах цагийн талаар гэрээ байгуулдаг уу?
 - d. Аман гэрээ байгуулдаг
 - e. Бичгээр гэрээ байгуулдаг
 - f. Үгүй → **3.13**
- 3.12. Гэрээнд тохирсон нөхцлүүд бүгд хэрэгждэг үү? (Олон сонголттой)
 - e. Тийм, гэрээнд заасан ажил үүрэг, ажлын цаг, цалин бүгд бодитоор хэрэгждэг
 - f. Үгүй, ажил үүрэг өөрчлөгддөг
 - g. Үгүй, цалин хөлс өөрчлөгддөг
 - h. Үгүй, ажлын цаг өөрчлөгддөг
- 3.13. Та энэ ажлыг хэр их хийдэг вэ?
 - d. Тогтмол
 - e. Хааяа
 - f. Онцгой байдал үүссэн үед хийдэг → **Бүлэг 4**
- 3.14. Энэ ажлыг сард хэдэн өдөр хийдэг вэ?
Өдрийн тоо.....
- 3.15. Энэ ажлыг өдөрт хэдэн цаг хийдэг вэ?
Өдрийн тоо..... → **Бүлэг 5**

4. Онцгой байдал үүссэний улмаас хийсэн ажил

- 4.1. Ямар онцгой байдал үүссэн бэ?
 - h. Зуд
 - i. Гал, түймэр
 - j. Үер
 - k. Газар хөдлөлт
 - l. Нийтийг хамарсан цар тахал
 - m. Амьтдын нүүдэл
 - n. Бусад.....

Ажилласан гэж сонгосон бүх онцгой байдал бүрээр доорх асуултуудыг асууна.

- 4.2. Та онцгой байдалд хэзээ ажилласан бэ?
Огноо.....
- 4.3. Та..... онцгой байдалд хэдэн өдөр ажилласан бэ?
Огноо.....
- 4.4. нөхцөлд ажиллахын өмнө таныг ямар нэг сургалтад хамруулсан уу?
- c. Тийм
 - d. Үгүй

5. Сургалт

- 5.1. Энэ ажлыг ямар нэг чадамж олгох сургалтын хүрээнд хийсэн үү?
- c. Тийм
 - d. Үгүй → **дуусгах**
- 5.2. Та энэ сургалтаар ямар ур чадвар эсвэл мэргэшил эзэмшсэн бэ ?
(бичих)
- 5.3. Та энэ сургалтад өөрийн хүсэлтээр сурсан уу?
- c. Тийм → **5.6**
 - d. Үгүй
- 5.4. Та ангийн удирдлагадаа энэ сургалтад суухаас татгалзаж буйгаа илэрхийлсэн үү?
- c. Тийм
 - d. Үгүй
- 5.5. Та сургалтад суухыг хүсээгүй боловч суусан шалтгаанаа сонгоно уу? (Олон сонголттой)
- j. Ангийн удирдлага хүссэн бөгөөд би тушаалыг зөрчиж чадахгүй
 - k. Би биеийн тамирын дасгал хийх шийтгэл хүлээхээс айдаг
 - l. Би чөлөөт цагаа хасуулах шийтгэл хүлээхээс айдаг
 - m. Би нэмэлт ажил хийх шийтгэлээс айдаг
 - n. Би хоригдох шийтгэл хүлээхээс айдаг
 - o. Би бусад цэргийн өмнө доромжлуулахыг хүсдэггүй
 - p. Би хийдэг ажил дээрээ тушаал буурахаас айдаг
 - q. Би бие махбодийн, бэлгийн гэх мэт хүчирхийллээс айдаг
 - г. Бусад.....
- 5.6. Та энэ сургалтаасаа гэрчилгээ авсан (авах) уу?
- 1. Тийм
 - 2. Үгүй

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА.

Эксперт, офицер, ахлагч нарын ярилцлагын асуулт

1. Ерөнхий мэдээлэл
 - а. Ажилласан жил, албан тушаал
2. Хугацаат цэргийн алба хаагчид ер нь ангидаа яаж хуваарилагддаг вэ?
3. Хугацаат цэргийн алба хаагчдад ямар сургалт явуулдаг вэ? Заавал болон өөрийн хүсэлтээр гэж хуваагддаг уу?
4. ЦАХ-дад энгийн мэргэжил мэргэшил олгох сургалт хийдэг үү? Мэргэжлийн гэрчилгээ өгдөг үү?
5. Ямар төрлийн ажлууд хийдэг вэ?
6. Улсыг хөгжүүлэхэд цэргийн оролцоо зайлшгүй чухал уу? Чухал бол яагаад? Үгүй бол яагаад?
7. Зэвсэгт хүчний хөгжлийн санд цэргийн хөдөлмөрөөс орсон орлогыг татаж байгаа нь хэр оновчтой вэ?
8. Гомдол шийдвэрлэх ажиллагаа үр дүнтэй эсэх, сайжруулах бол санал
9. 29, 105-р конвенцын талаар сургалт, мэдээлэл авч байсан уу? Сургалтын хөтөлбөрт энэ талаарх мэдээлэл туссан уу?
10. МУ-ын хууль тогтоомж нь ОУХБ-ын албадан хөдөлмөрийн тухай 29, 105-р конвенцод нийцэж байгаа юу?

Нэмэлт

11. Цэргийн албанд ажилладаг албан тушаалтнууд албанаасаа өөрийн хүслээр гарах нь хэр элбэг байдаг вэ?
12. Офицер цэргийн албанаас чөлөөлөгдөх ямар процедур байдаг вэ? Чөлөөлөгдөх өргөдөл хэр хурдан шийдэгддэг вэ?

Цэргийн албанд ажиллаж байгаа алба хаагчидтай хийх ярилцлагын асуулт

1. Цэргийн албанаас чөлөөлөгдөх боломжтой юу?
2. Чөлөөлөгдөх бол ямар процедур байдаг болох
3. Өөрийн хүсэлт гаргахад шийдээгүй тохиолдол байсан уу? Байсан бол шалтгаан?
4. Чөлөөлөгдөх нь ямар нэг дарамт, шахалт, гадуурхалтад өртөх шалтгаан болдог уу?
5. ЦАХ ямар төрлийн ажлууд хийж байгаа вэ?
6. Улсыг хөгжүүлэхэд цэргийн оролцоо зайлшгүй чухал уу? Чухал бол яагаад? Үгүй бол яагаад?
7. Зэвсэгт хүчний хөгжлийн санд цэргийн хөдөлмөрөөс орсон орлогыг татаж байгаа нь хэр оновчтой вэ?
8. Гомдол гаргах ажиллагаа үр дүнтэй юу?
9. Гомдол гаргах журамд өөрчлөлт оруулах бол ямар өөрчлөлт хэрэгтэй вэ?
10. Ихэвчлэн ямар асуудлаар гомдол гаргадаг вэ?
11. 29, 105-р конвенцын талаар сургалт, мэдээлэл авч байсан уу?
12. МУ-ын хууль тогтоомж нь ОУХБ-ын албан хөдөлмөрийн тухай 29, 105-р конвенцод нийцэж байгаа юу?

Хугацаат цэргийн алба хаагчидтай хийх ярилцлагын асуулт

1. Цэргийн алба хааж байхдаа ямар ямар ажил хийж байсан бэ?
2. Эдгээр ажлууд дотор танд таалагддаг нь ямар ажлууд вэ? Яагаад?
3. Эдгээр ажлаас танд таалагддаггүй нь ямар ажил вэ? Яагаад?
4. Таалагддаггүй бол та яагаад тэдгээр ажлыг хийсэн бэ?
5. Халагдсанаас хойш ижил төстэй ажил хийсэн үү? Яагаад?
6. Энгийн иргэний хувьд ажиллахаас цэргийн албанд ажиллахын давуу тал юу вэ? Сул тал юу вэ?
 - a. Ажлын нөхцөлийн хувьд
 - b. Цалин хөлсний хувьд
 - c. Мэргэшил ур чадвар олгохын хувьд
7. Та цэргийн алба хааж ажил хийж хуримтлалтай болохыг ах дүүдээ санал болгох уу? Яагаад?
8. Халагдахдаа хэдэн төгрөгийн хуримтлалтай болсон бэ?
9. Ажил хийх үед дарамт, шахалт, гадуурхалт тулгардаг уу?
10. Тулгарсан бол хэрхэн шийдсэн бэ?
11. Шийдээгүй бол яагаад?
12. Хэдэн төгрөгийн ажил хийж байгаа, хэдэн төгрөгийн урамшуулал авдаг зэргээ тодорхой мэдэж байсан уу?
13. Улсыг хөгжүүлэхэд цэргийн оролцоо зайлшгүй чухал уу? Чухал бол яагаад? Үгүй бол яагаад?
14. Зэвсэгт хүчний хөгжлийн санд цэргийн хөдөлмөрөөс орсон орлогыг татаж байгаа нь хэр оновчтой вэ?
15. Алба хааж байх хугацаандаа цэргийн үүрэгтэй холбоогүй ямар ямар сургалтад суусан бэ?
16. Сургалтад өөрийн хүсэлтээ гаргаж суусан уу? Үгүй бол хэрхэн суусан?
17. Гомдол гаргах ажиллагаа үр дүнтэй юу?
18. Гомдол гаргах журамд өөрчлөлт оруулах бол ямар өөрчлөлт хэрэгтэй вэ?
19. Ихэвчлэн ямар асуудлаар гомдол гаргадаг вэ?
20. ОУХБ-ын албадан хөдөлмөрийн тухай 29, 105-р конвенцын тухай сонсож байсан уу?

Халагдсан цэргүүдтэй хийх ярилцлагын асуулт

1. Цэргийн алба хааж байхдаа ямар ямар ажил хийж байсан бэ?
2. Эдгээр ажлууд дотор танд таалагддаг нь ямар ажлууд вэ? Яагаад?
3. Эдгээр ажлаас танд таалагддаггүй нь ямар ажил вэ? Яагаад?
4. Таалагддаггүй бол та яагаад тэдгээр ажлыг хийсэн бэ?
5. Халагдсанаас хойш ижил төстэй ажил хийсэн үү? Яагаад?
6. Энгийн иргэний хувьд ажиллахаас цэргийн албанд ажиллахын давуу тал юу вэ? Сул тал юу вэ?
 - a. Ажлын нөхцөлийн хувьд
 - b. Цалин хөлсний хувьд
 - c. Мэргэшил ур чадвар олгохын хувьд
7. Та цэргийн алба хааж ажил хийж хуримтлалтай болохыг ах дүүдээ санал болгох уу? Яагаад?
8. Халагдахдаа хэдэн төгрөгийн хуримтлалтай болсон бэ?
9. Ажил хийх үед дарамт, шахалт, гадуурхалт тулгардаг уу?
10. Тулгарсан бол хэрхэн шийдсэн бэ?
11. Шийдээгүй бол яагаад?

12. Хэдэн төгрөгийн ажил хийж байгаа, хэдэн төгрөгийн урамшуулал авдаг зэргээ тодорхой мэдэж байсан уу?
13. Улсыг хөгжүүлэхэд цэргийн оролцоо зайлшгүй чухал уу? Чухал бол яагаад? Үгүй бол яагаад?
14. Зэвсэгт хүчний хөгжлийн санд цэргийн хөдөлмөрөөс орсон орлогыг татаж байгаа нь хэр оновчтой вэ?
15. Алба хааж байх хугацаандаа цэргийн үүрэгтэй холбоогүй ямар ямар сургалтад суусан бэ?
16. Сургалтад өөрийн хүсэлтээ гаргаж суусан уу? Үгүй бол хэрхэн суусан?
17. Гомдол гаргах ажиллагаа үр дүнтэй юу?
18. Гомдол гаргах журамд өөрчлөлт оруулах бол ямар өөрчлөлт хэрэгтэй вэ?
19. Ихэвчлэн ямар асуудлаар гомдол гаргадаг вэ?
20. ОУХБ-ын албадан хөдөлмөрийн тухай 29, 105-р конвенцын тухай сонсож байсан уу?